

ᠮᠣᠩᠭᠡᠯᠠᠭᠤᠨ
ᠲᠦᠨᠲᠦᠨ
ᠲᠦᠨᠲᠦᠨ
ᠲᠦᠨᠲᠦᠨ



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН | 2020

Монгол Улсын Төрийн аудитын байгууллагын 2020 оны үйл ажиллагааны тайланг хуульд заасны дагуу нээлттэй, ил тод байх зарчмын дагуу бэлтгэн гаргав.

Энэхүү тайлантай холбоотой санал хүсэлт, лавлах зүйл байвал Үндэсний аудитын газрын info@audit.gov.mn цахим шууданд ирүүлнэ үү.

ӨМНӨХ ҮГ	5
ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН 2020 ОНЫ ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	7
2020 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ	8
1 БҮЛЭГ ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ	10
Төрийн аудитын байгууллагын стратеги	12
Төрийн аудитын байгууллагын бүтэц, зохион байгуулалт	13
Хүний нөөц	14
Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаа	15
Төрийн аудитын эрх зүйн шинэчлэл	16
Төрийн аудитын стандартын шинэчлэл	17
2 БҮЛЭГ 2020 ОНД ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТЫН ҮР ДҮН	18
Хураангуй тойм	20
Санхүүгийн тайлангийн аудит	22
Гүйцэтгэлийн аудит	28
Нийцлийн аудит	38
3 БҮЛЭГ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, АУДИТЫГ ДЭМЖИХ ҮЙЛЧИЛГЭЭ	46
Удирдлага, зохион байгуулалт	48
Эрх зүйн дэмжих үйлчилгээ	50
Аудитын хөгжүүлэлт	51
Цахим сургалт, хөгжлийн арга хэмжээ	52
Гадаад сургалт	53
Судалгаа шинжилгээ, төсөл хөтөлбөр	54
Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит	55
Чанарын баталгаажуулалт	55
Ил тод байдал	56
Мэдээллийн технологи	58
Мэдээллийн системийн тасралтгүй ажиллагаа, аюулгүй байдал	59
Гадаад харилцаа, хамтын ажиллагаа	60
Төрийн аудитын байгууллагын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлагнал	61
4 БҮЛЭГ ДҮГНЭЛТ, ЦААШДЫН ЗОРИЛТ	62
5 БҮЛЭГ СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН	66
6 БҮЛЭГ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГСӨН ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	74
ХАВСРАЛТ	78

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АИ ДИ АИ	Хөгжлийн санаачилга
АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар
АНТАГ	Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АДБ	Аудитын Дээд Байгууллага
АСОСАИ	Аудитын Дээд Байгууллагуудын Азийн Байгууллага
АХБ	Азийн хөгжлийн банк
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
БНСВУ	Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс
БНТУ	Бүгд Найрамдах Турк Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНЭУ	Бүгд Найрамдах Энэтхэг Улс
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
БЦГ	Байгалийн цогцолбор газар
БХГ	Бүтээгдэхүүн хуваах гэрээ
ГТБҮ	Газрын тос боловсруулах үйлдвэр
ГХГЗЗГ	Газрын харилцаа, геодези зураг зүйн газар
ЖДҮДС	Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сан
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗТХЯ	Зам, тээврийн хөгжлийн яам
ИНТОСАИ	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Байгууллага
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЕАБХАБ	Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага
ММНБИ	Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МУЕАО	Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОХУ	Оросын Холбооны Улс
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
СТАУС	Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын систем
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ТАГ	Төрийн аудитын газар
ТБХ	Төсвийн байнгын хороо
ТЕГ	Татварын ерөнхий газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТБТХ	Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮАБЗ	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШДНЦХ	Шилэн дансны нэгдсэн цахим хуудас
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭХЯ	Эрчим хүчний яам

ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын Төрийн аудитын байгууллагын 2020 оны үйл ажиллагааны тайланг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны 05 дугаар тогтоолын дагуу хийсэн системчилсэн үнэлгээний тайлан болон санхүүгийн тайланд хараат бус аудитын компанийн гаргасан дүгнэлтийн хамт та бүхэнд өргөн барьж байна.

Төрийн аудитын байгууллагын 2020 оны үндсэн зорилтыг “Төрийн аудитын байгууллагын эрх зүйн орчин, стандартын шинэтгэлийн жил” гэж тодорхойлж, уг зорилт амжилттай биелэгдсэний сацуу энэхүү үйл явцад хувь нэмрээ оруулсан нийт хамт олон, үйл ажиллагааны эрх зүйн орчныг бататгаж өгсөн Монгол Улсын Их Хурал, бидний ажлыг дэмжиж ажилласан төрийн байгууллага, харилцагч талуудад талархал илэрхийлж байна.

Төрийн аудитын байгууллага улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулахыг эрхэмлэн хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийн хүрээнд аудитыг цаг хугацаанд нь үр нөлөөтэй гүйцэтгэж, үр дүнг тайлагнах, аудитын шийдвэр болон түүний мөрөөр үр өгөөжийг тооцон ажиллалаа.

Тайлант хугацаанд эрх зүйн шинэтгэлийн зорилтын хүрээнд бий болсон хүлээлт, Үндсэн хуулиар “Төрийн аудит”-ыг хуульчлан бататгасан өөрчлөлтөд нийцсэн зохион байгуулалт, бүтцийн шинэчлэлээ хянан үзэж төрийн аудитын байгууллагын хэтийн хөгжлийн бодлого, стратегийг дэмжсэн суурь шинэчлэл, өөрчлөлт хийхийг зорилоо.

Энэ хүрээнд эрх зүйн орчин, стандартын шинэтгэлийн жилийн зорилтоо дэмжиж



зохион байгуулалтын бүтэц, чиг үүрэг, үйл ажиллагаа нь хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд нийцсэн, харилцагч талууд, гадаад орчинтой үр нөлөөтэй хамтран ажиллах, дотоод бүтцийн нэгжүүдийн уялдааг хангахад чиглүүлэн аливаа давхардал, хийдэлгүйгээр төрийн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхүйц зохион байгуулалтын бүтэц, тогтолцоог төлөвшүүлэх бодлогыг чухалчилсан болно.

Монгол Улсын Их Хурлын болон орон нутгийн ээлжит сонгуулийн үйл явцад Төрийн аудитын байгууллагаас хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд нийцсэн журам, заавар, аргачлалыг батлан хэрэгжүүлснээр Монгол Улсын хууль тогтоох болон шат шатны сонгуульт байгууллага зохион байгуулагдаж, үйл ажиллагаагаа эхлүүлэхэд хуулийн хүрээнд зохих хувь нэмрээ оруулсныг онцлон тэмдэглэж байна.

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос баталсан аудитын сэдэв, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан нарийвчилсан төлөвлөгөөний дагуу санхүүгийн тайлангийн 3825, гүйцэтгэлийн 160, нийцлийн 156 буюу нийт 4141 аудитыг хийж гүйцэтгэн улс, орон нутгийн төсөвт 40.1 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Төрийн аудитыг нэгтгэн удирдах тогтолцоог төлөвшүүлж цахимжуулах, дэлхий нийтийг хамарсан цар тахлын сөрөг үр дагаврыг бууруулахын тулд улс орнуудын аудитын дээд байгууллагуудын нэгэн адил улс, нийтэд учирч болзошгүй эрсдэлд суурилсан, аливаа хямралын эсрэг аудитыг зорилтот сэдвийн хүрээнд буюу олон нийтийн анхааралд байгаа нийтийн ашиг сонирхлыг

хөндсөн бодит цаг хугацааны стратегийн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхийг эрхэмлэн ажилладаг.

Төрийн аудитын байгууллага олгогдсон бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын хууль тогтоох байгууллагын хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлж, улмаар үндэсний болоод нийтийн эрх ашгийн төлөө гүйцэтгэх засаглалын хүлээх хариуцлага, тэдгээрийн хүрээний байгууллагуудын зохион байгуулалт, үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх, нийтийн хөрөнгийн захиран зарцуулалтад тавих хяналтыг Үндсэн хуулиар олгогдсон хууль дээдлэх, шударга ёсыг хангах, ил тод, нээлттэй, бодитой байх төрийн аудитын үндсэн зарчмыг удирдлага болгон цаашид олсон ололтоо бататган ажиллах болно.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ЗАНДАНБАТ

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН 2020 ОНЫ ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ



4141

гүйцэтгэсэн
аудит



3825

санхүүгийн
тайланд
гаргасан дүгнэлт



316

гүйцэтгэл,
нийцлийн
аудит



9,365.7

тэрбум төгрөг
алдаа зөрчил



7156

зөвлөмж



4,653.7

тэрбум төгрөг
залруулсан
алдаа



3,483.0

тэрбум төгрөг
алдаа зөрчил
илрүүлсэн



2734

зөвлөмж



65.8

тэрбум төгрөг
төсвийн төсөлд
хэрэгжсэн санал



40.1

тэрбум төгрөг
улс, орон
нутгийн төсөвт
төвлөрүүлсэн



359.6

тэрбум төгрөг
хүлээн
зөвшөөрүүлсэн
үр өгөөж



18.6

төгрөг
санхүүжилтийн
төгрөг тутамд бий
болсон үр өгөөж



72

хуулийн
байгууллагад
шилжүүлсэн
асуудал



47

шийдвэрлэгдсэн
асуудал



560

албан тушаалтанд
хариуцлага
тооцуулсан



115

сургалт



394

нийт
албан хаагч



93.6%

төсвийн
гүйцэтгэл



Үндсэн хууль:
Төрийн аудитын
байгууллагын
ХАРААТ БУС БАЙДАЛ-ыг
баталгаажуулав

“Монгол Улсын Үндсэн хууль”-д оруулсан нэмэлт өөрчлөлтийн холбогдох заалтад “Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно” гэж хуульчилсан нь Төрийн аудитын байгууллагын хараат бус байдлын зарчмыг баталгаажуулсан.



УИХ-ын 2020 оны
02 тогтоол: Үндсэн
хуулийн нэмэлт
өөрчлөлтөд нийцүүлэн
**Төрийн аудитын тухай
хуулийн шинэчилсэн
найруулга** батлагдав

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолд заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд холбогдох хууль тогтоомжийг нийцүүлэх ажлын хүрээнд Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Монгол Улсын Их Хуралд өргөн барьж, 2020 оны 5 дугаар сарын 01-ний өдөр баталжээ.



**Төрийн аудитын
стандарт**
MNS 6817:2020-ийг
батлуулав

Төрийн аудитын байгууллага Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллагаас батлан гаргасан, гишүүн орнуудад хүлээн зөвшөөрөгдсөн аудитын бодлого, арга зүй, нийтлэг ашиглагдах стандарт, удирдамжид нийцсэн “Төрийн аудит MNS 6817:2020” стандартыг батлуулав.



Төрийн аудитын
байгууллагын 2019
оны үйл ажиллагааны
тайланг хэлэлцэв

Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар Төрийн аудитын байгууллагын 2019 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэв.



Төрийн аудитын тухай
хууль (шинэчилсэн
найруулга)-д нийцүүлэн
холбогдох дүрэм, журам,
заавар, аргачлалыг
батлав

Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар тайлант онд нийт 23 дүрэм, журам, заавар, аргачлалыг шинэчлэн боловсруулж баталснаас 12 нь аудитын үйл ажиллагаатай холбоотой журам, заавар, аргачлал байна.



ИНТОСАИ-н
“Ажлын хэсэг”-ийн
ажиглагч гишүүн
болов

Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд мэдээллийн технологийн хөгжлийг нэвтрүүлэх зорилтын хүрээнд ИНТОСАИ-н “Аудитад үзүүлэх шинжлэх ухаан, технологийн нөлөөллийн ажлын хэсэг”-ийн ажиглагч гишүүн болов.



Төрийн аудитын
байгууллагын
гүйцэтгэлийн хэмжүүрийн
тогтолцоонд үнэлгээ
өгөв

ИНТОСАИ, АСОСАИ-тай хамтран Аудитын дээд байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилго бүхий АДБ-ын гүйцэтгэлийн хэмжүүрийн тогтолцоонд үнэлгээ хийх чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрт хамрагдаж, Төрийн аудитын байгууллагын гүйцэтгэлийн хэмжүүрийн тогтолцоонд үнэлгээ хийлээ.



Монгол Улсын Их Хурлын
болон орон нутгийн 2020
оны ээлжит сонгуультай
холбоотой аудит хийж,
дүгнэлт гаргав

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн дагуу нэр дэвшигч, нам, эвслийн зардлын дээд хэмжээг тогтоох, мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах, хандивын тайлан, сонгуулийн зардлын тайланг баталгаажуулах аудитыг гүйцэтгэлээ.



Сургалтын
цахим системийг
нэвтрүүлэв

Төрийн аудитын байгууллагын 2019-2024 оны стратегийн төлөвлөгөөний “Нийгмийн бүхий л салбарыг хамарсан өргөн хүрээний асуудалд үнэлэлт, дүгнэлт өгөх мэдлэг, чадвар бүхий хүний нөөцийг бүрдүүлэх” зорилтын хүрээнд албан хаагчдад зориулсан цахим сургалтын системийн үйл ажиллагааг нэвтрүүлэв.



Төрийн аудитын
үйл ажиллагаанд
иргэдийн оролцоог
хангах 2020-2023
стратегийг боловсруулж
хэрэгжүүлж эхлэв

Монгол Улсын Үндэсний аудитын газрын санаачилгаар “Төрийн аудитын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах 2020-2023 оны стратеги”-ийг Европын холбооны итгэлцлийн сангийн санхүүжилтээр Дэлхийн банкны хэрэгжүүлж буй засаглалыг бэхжүүлэх төслийн хүрээнд боловсруулан батлууллаа.

ᠮᠤᠩᠭᠡᠯᠤᠯᠤᠰᠤᠨ
ᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠨ
ᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠨ
ᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠨ
ᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠨ
ᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠨ
ᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠨ



1

ТӨРИЙН АУДИТЫН
БАЙГУУЛЛАГЫН
ТУХАЙ



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИ

АЛСЫН ХАРАА

Монгол Улсын хөгжлийн бодлого, зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн эдийн засаг, нийгмийн өндөр үр нөлөөтэй төрийн аудитыг гүйцэтгэж, арга зүй, технологи, үйл ажиллагаагаар бүс нутгийн хэмжээнд тэргүүлэх аудитын дээд байгууллага болно.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлж, харилцагч талуудын хамтын ажиллагааг сайжруулах замаар иргэдийн амьдралыг сайжруулна.

ЭРХЭМЛЭХ ҮНДСЭН ЗАРЧИМ



Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4	Зорилт 5	Зорилт 6
Төрийн аудитын байгууллагын хараат бус байдал, хууль эрх зүйн орчныг бэхжүүлэх	Төрийн аудитын тогтолцоонд арга зүй, стандартын шинэчлэлийг хийж, олон улсын чиг хандлагад нийцсэн дэвшилтэт технологи бүхий орчин үеийн төрийн аудитын тогтолцоог төлөвшүүлэх	"Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030"-г хэрэгжүүлэх төрийн аудитын байгууллагын идэвх оролцоог нэмэгдүүлэх замаар сайн засаглалыг дэмжих	Харилцагч талуудын үр ашигтай хамтын ажиллагааг дэмжиж, аудитын чанар, нийгэмд үзүүлэх үр өгөөжийг дээшлүүлэх	Нийгмийн бүхий л салбарыг хамарсан өргөн хүрээний асуудалд үнэлэлт, дүгнэлт өгөх мэдлэг, чадвар бүхий хүний нөөцийг бүрдүүлэх	Төрийн аудитын байгууллагын дотоод засаглал, дэмжих үйлчилгээ, эрсдэлийн удирдлагын тогтолцоог төлөвшүүлэх

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛТ

2020 он

Төрийн аудитын байгууллагын эрх зүйн орчин, стандартын шинэтгэлийн жил

Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлттэй холбоотойгоор "Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулга" батлагдсан.

АДБОУС-аас гаргасан аудитын стандартыг Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн хянаж "ТӨРИЙН АУДИТ MNS 6817:2020" Монгол Улсын стандартыг баталсан.

2021 он

Аудитыг цахимжуулж нэгтгэн удирдах тогтолцоог бүрдүүлж, төлөвшүүлэх

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР



6 жилийн хугацаатай УИХ-аас томилдог.
1 удаа улируулан томилж болно.


УИХ-ын 2019 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдааны 46 дугаар тогтоолоор Монгол Улсын Ерөнхий аудитораар Доржсүрэн овогтой Занданбат томилогдон ажиллаж байна.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ

УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны 01 дүгээр тогтоолыг үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/02 дугаар тушаалаар Үндэсний аудитын газрын зохион байгуулалтын бүтэц, бүтцийн нэгжүүдийн үндсэн үйл ажиллагааны чиг үүрэг, орон тоо,

албан тушаалын жагсаалтыг шинэчлэн баталж мөрдөн ажиллав.

Энэ тушаалын дагуу 394 албан хаагч, 7 газар, 1 хэлтэс, 21 аймаг, нийслэлд Төрийн аудитын газар үйл ажиллагаа явуулж байна.



Тайлбар:


- МУЕА-ын шууд удирдлага
- Тэргүүлэх аудиторын шууд удирдлага
- Үндсэн бүтцийн нэгж
- Дэмжих үйлчилгээ

ХҮНИЙ НӨӨЦ

Төрийн аудитын байгууллагад мөрдөж буй хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой дүрэм журмын хэрэгжилтийг хангах, зохих хяналтыг хэрэгжүүлж, нийгмийн баталгааг хангах ажлыг гүйцэтгэв.


УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2020 оны 06 дугаар тогтоолоор Төрийн аудитын байгууллагын үндсэн үйл ажиллагааг дэмжиж орон тооны хязгаарыг өөрчлөн баталсан байна.

Байгууллагын бүтцээр



- Үндэсний аудитын газар
- Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар

Чиг үүргээр



- Удирдлага, дэмжих үйлчилгээ
- Аудит гүйцэтгэж буй

Ажилласан жилээр	0-5 хүртэл жил	6-10 жил	11-15 жил	15- аас дээш жил
	8.6%	17.9%	23.0%	50.5%
	9.3%	39.6%	30.1%	21%
Насны бүлгээр	30 хүртэлх нас	31-40 нас	41-50 нас	51-60 нас

Төрийн аудитын байгууллагын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд:



144 албан хаагчид
135.8 сая төгрөгийн
буцалтгүй тусламж




13 ажилтан
өндөр насны тэтгэвэрт
гарахад 421.5 сая
төгрөгийн тэтгэмж

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төрийн аудитын байгууллага улсын хөгжлийн зорилтуудыг шийдвэрлэхэд зарцуулж байгаа төрийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд материаллаг эрсдэл өндөр байгаа газар, төсөл хөтөлбөр, нийгмийн хариуцлага шаардсан эдийн

засгийн салбарууд, нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудал, үйл ажиллагаанд аудит хийх чиглэлд түлхүү анхаарч шударга, ил тод байдлыг бий болгож дэмжих, УИХ-ыг хараат бус бие даасан, үнэн зөв мэдээллээр хангахыг зорьдог.



Тайлбар:

1

Монгол Улсын Ерөнхий аудитор төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны жилийн тайланг хуульд заасан хугацаанд Улсын Их Хурлын холбогдох байнгын хороонд хүргүүлнэ.

Монгол Улсын Ерөнхий аудитор төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны хараат бус байдал, зохион байгуулалттай холбоотой асуудлаар Улсын Их Хуралд санал хүргүүлж, шийдвэрлүүлнэ.

Монгол Улсын Ерөнхий аудитор аудитын сэдвийг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд танилцуулж, шийдвэрлүүлнэ.

3

Төрийн аудитын байгууллага аудитын тайланг шалгагдагч этгээд, Улсын Их Хурал, шаардлагатай тохиолдолд Засгийн газар болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

2

Монгол Улсын Ерөнхий аудитор төрийн санхүү, төсөв, нийтийн өмчийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй төлөвлөх, хуваарилах, ашиглах, захиран зарцуулахад хамаарах аливаа асуудлаар санал, дүгнэлт, зөвлөмж бэлтгэж, Улсын Их Хуралд танилцуулж болно.

Монгол Улсын Их Хурлын холбогдох байнгын хороонд хуульд заасны дагуу Төрийн аудитын байгууллагын гүйцэтгэсэн аудитын тайланг хүргүүлнэ.

4

Төрийн аудитын байгууллага төрийн болон албаны, байгууллагын, хувь хүний нууцад хамаарах мэдээлэл агуулснаас бусад аудитын тайланг Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасан журмын дагуу улирал бүр гаргаж, өөрийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлнэ.

ТӨРИЙН АУДИТЫН ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ

Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хүрээнд хуулийн төслийн хамт 4 сэдвээр баримт бичиг боловсруулж, 4 чиглэлээр хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийсний дээр бусад 8 улс орны төрийн аудитын дээд байгууллагын хууль тогтоомжийг судалгаанд ашиглан, шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн 6 хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулсан байна.

Төрийн аудитын байгууллага 2020 оныг “Төрийн аудитын байгууллагын эрх зүйн орчин, стандартын шинэтгэлийн жил” болгосны дагуу Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2020 оны 3 дугаар сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн барьсан юм.

УИХ-ын 2020 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг

бүхэлд нь дэмжих санал хураалтаар гишүүдийн 78 хувь нь дэмжиж баталснаар “Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу Үндэсний аудитын газар Үндсэн хуулийн буюу хараат бус төрийн аудитын байгууллага болох хууль эрх зүйн шинэ орчин бий болсон түүхэн жил болж үлдлээ.

Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулга нь Нэгд, Төрийн аудитын үйл ажиллагаа хөндлөнгийн зүй бус нөлөөллөөс ангид байх баталгаа хангагдаж, хараат бус, бие даасан байдлаар төрийн санхүү, төсвийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санаа бодитоор хэрэгжих боломжтой болж байна. Хоёрт, Төрийн аудитын олон улсын стандартыг баримтлах, албан тушаалтны учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх үүргийн хэрэгжилтийг мэдээлэх боломжтой болж төрийн аудитын шийдвэр бүрэн хангагдах нөхцөл бүрдэж байна.

ТӨРИЙН АУДИТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА

<p style="text-align: center; font-weight: bold; font-size: small;">МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭМЭЛТ</p> <p style="font-size: x-small;">“Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.”</p>	<p style="text-align: center; font-weight: bold; font-size: small;">ТӨРИЙН АУДИТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗОРИЛГО</p> <p style="font-size: x-small;">Төрийн санхүү, төсөв, нийтийн өмчийг зохистой төлөвлөх, ашиглах, зарцуулахад тавих хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, тогтолцоо, зохион байгуулалт, эрх зүйн үндсийг тогтооход оршино.</p>	<p style="text-align: center; font-weight: bold; font-size: small;">ТӨРИЙН АУДИТЫН ТУХАЙ ХУУЛЬ</p> <p style="font-size: x-small;">6 бүлэг, 43 зүйл, 225 заалт</p>
---	--	---


<p style="text-align: center; font-size: small;">Хараат бус байдал</p> <p style="font-size: x-small;">Төрийн аудитын байгууллагын бие даасан, үйл ажиллагааны хараат бус байдлыг сайжруулах, эрх хэмжээг нэмэгдүүлэх, зохион байгуулалт, үйл ажиллагаа тодорхой болсон.</p>	<p style="text-align: center; font-size: small;">Аудитын сэдэв сонголт</p> <p style="font-size: x-small;">Аудитын төлөвлөлт боловсронгуй болж, төлөвлөгөөт бус аудит хийх эрх зүйн орчин бүрдсэн.</p>	<p style="text-align: center; font-size: small;">Гэмт хэргийн шинжтэй үйлдэл</p> <p style="font-size: x-small;">Аудит хийх явцад гэмт хэргийн шинжтэй үйлдэл илэрсэн тохиолдолд холбогдох байгууллагад мэдэгдэж, эрүүгийн хэрг үүсгүүлэн шалгуулах боломжтой болсон.</p>
<p style="text-align: center; font-size: small;">Эрх зүйн орчин</p> <p style="font-size: x-small;">Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх, нийтийн өмчийг зохистойгоор төлөвлөх, тайлагнах, ашиглах, зарцуулах үйл ажиллагаанд тавих хяналтын эрх зүйн орчин бүрдсэн.</p>	<p style="text-align: center; font-size: small;">Мэдээллийн технологи</p> <p style="font-size: x-small;">Төрийн аудитын байгууллага үр дүнтэй, үр ашгтай аудитыг хийхийн тулд шинжлэх ухааны ололт, орчин үеийн мэдээллийн технологийн арга, хэлбэрийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх боломж эрхзүйн үндэс бий болсон.</p>	<p style="text-align: center; font-size: small;">Нөлөөллийн мэдүүлэг</p> <p style="font-size: x-small;">Төрийн аудитор бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь саад учруулсан аливаа дарамт, шалхалт, хууль бус нөлөөллийн талар нөлөөллийн мэдүүлэг хөтөлнө.</p>
<p style="text-align: center; font-size: small;">Эдийн засгийн баталгаа</p> <p style="font-size: x-small;">Төрийн аудитын байгууллага үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэхэд хүрэлцээтэй эдийн засгийн баталгаа хангагдсан.</p>	<p style="text-align: center; font-size: small;">Төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх</p> <p style="font-size: x-small;">Төрийн албан тушаалтны төрд учруулсан хохирлыг төлүүлэх үүргийн хэрэгжилтийг мэдээлэх боломж бүрдсэн.</p>	<p style="text-align: center; font-size: small;">Хариуцлага тооцоулах</p> <p style="font-size: x-small;">Нийтийн өмч, төсвийг ашиглах, зарцуулахдаа сахилга бат алдсан албан хаагчид хариуцлага тооцох механизм тодорхой болсон.</p>
<p style="text-align: center; font-size: small;">Төрийн аудитын стандарт</p> <p style="font-size: x-small;">Аудитын үйл ажиллагаа Аудитын дээд байгууллагын Олон Улсын стандартад нийцсэн төрийн аудитын үндэсний стандартыг бий болгоно.</p>	<p style="text-align: center; font-size: small;">Акт, албан шаардлага, зөвлөмж</p> <p style="font-size: x-small;">Аудитын албан шаардлага, төлбөрийн акт заавал биелэгдэх эрх зүйн орчин тодорхой болсон.</p>	<p style="text-align: center; font-size: small;">Мэдээлэл авах эрх</p> <p style="font-size: x-small;">Төрийн аудитын байгууллагын албан хаагч аудит хийх үедээ мэдээлэлээр бүрэн хангагдах боломжтой болсон.</p>

<p style="text-align: center; font-weight: bold; font-size: small;">НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТУХАЙ</p> <ul style="list-style-type: none"> * Төрийн аудитын тухай хуулийг хүчингүй болгосонд тооцох тухай; * Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай; * Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай; * Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай; * Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай; * Аудитын тухай хуульд нэмэлт оруулах тухай; * Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай. 	<p style="text-align: center; font-weight: bold; font-size: small;">ОЛОН НИЙТЭД ТҮГЭЭСЭН БАЙДАЛ</p> <table style="width: 100%; font-size: x-small;"> <tr> <td style="width: 50%; vertical-align: top;"> <p>1 УИХ-ын хэвлэлийн албанаас 16 албан мэдээ гаргаж, 48 удаа хуулбарлан нийтэлсэн байна.</p> <p>8 Видео хэлбэрээр</p> </td> <td style="width: 50%; vertical-align: top;"> <p>2 Хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр олон нийтэд түгээсэн мэдээллийн тоо:</p> <p>36 Телевизийн мэдээллийн хөтөлбөр</p> <p>22 Өдөр тутмын сонин</p> <p>59 Мэдээний вэбсайт</p> <p>27 Бусад цахим хуудсаар</p> <p>5 цуврал 96 минутын подкаст</p> </td> </tr> </table>	<p>1 УИХ-ын хэвлэлийн албанаас 16 албан мэдээ гаргаж, 48 удаа хуулбарлан нийтэлсэн байна.</p> <p>8 Видео хэлбэрээр</p>	<p>2 Хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр олон нийтэд түгээсэн мэдээллийн тоо:</p> <p>36 Телевизийн мэдээллийн хөтөлбөр</p> <p>22 Өдөр тутмын сонин</p> <p>59 Мэдээний вэбсайт</p> <p>27 Бусад цахим хуудсаар</p> <p>5 цуврал 96 минутын подкаст</p>
<p>1 УИХ-ын хэвлэлийн албанаас 16 албан мэдээ гаргаж, 48 удаа хуулбарлан нийтэлсэн байна.</p> <p>8 Видео хэлбэрээр</p>	<p>2 Хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр олон нийтэд түгээсэн мэдээллийн тоо:</p> <p>36 Телевизийн мэдээллийн хөтөлбөр</p> <p>22 Өдөр тутмын сонин</p> <p>59 Мэдээний вэбсайт</p> <p>27 Бусад цахим хуудсаар</p> <p>5 цуврал 96 минутын подкаст</p>		

ТӨРИЙН АУДИТЫН СТАНДАРТЫН ШИНЭЧЛЭЛ

Төрийн аудитын байгууллага чиг үүргээ гүйцэтгэхдээ ИНТОСАИ-н Мэргэжлийн стандартын хорооноос баталсан Аудитын дээд байгууллагын олон улсын стандартыг баримталж байна.

Хуулийн шаардлагад нийцүүлэн “Төрийн аудит MNS 6817:2020” стандартыг батлуулсан нь аудитын бодлого, арга зүйг боловсронгуй болгох, чанар, үр нөлөөг дээшлүүлэх нэг алхам болсон юм.



ТӨРИЙН АУДИТ MNS 6817:2020 СТАНДАРТ

Төрийн аудитын стандартын зорилго нь аудитын үндсэн ойлголт, зарчмыг тодорхой болгон ил тод байдал, чанарыг хангаж, аудитыг

тайлагнан, үр дүнд хэрэглэгчдийн итгэх итгэлийг бэхжүүлэхэд оршино.

MNS 6817-1:2020 / АДБОУС 100

Төрийн аудитын тулгуур зарчим

Төрийн аудитыг гүйцэтгэхдээ аудитын төрөл хэлбэрийг үл харгалзан нийтлэг мөрдөх ерөнхий болон аудитын үйл явцтай холбоотой тулгуур зарчмыг тодорхойлсон.

MNS 6817-2:2020 / АДБОУС 130

Ёс зүйн дүрэм

Төрийн аудитын байгууллага болон ажилтанд зан байдлын суурь болгон мөрдөх ёс зүйн үнэт зүйлс болон зарчмыг тусгасан.

MNS 6817-3:2020 / АДБОУС 140

Аудитын дээд байгууллагын чанарын хяналт

Аудитын дээд байгууллага аудитын үйл явцад тавих чанарын хяналтын зохистой тогтолцоо бүрдүүлж, хэрэгжүүлж байх ёстой талаарх зарчмыг тусгасан.

MNS 6817-4:2020 / АДБОУС 200

Санхүүгийн аудитын тулгуур зарчим

Санхүүгийн тайланд хийх аудитын тулгуур зарчмыг тодорхойлсон.

MNS 6817-5:2020 / АДБОУС 300

Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим

Гүйцэтгэлийн аудит хийхдээ баримтлах тулгуур зарчмыг тодорхойлсон.

MNS 6817-6:2020 / АДБОУС 400

Нийцлийн аудитын тулгуур зарчим

Нийцлийн аудит хийхдээ баримтлах тулгуур зарчмыг тодорхойлсон.

MNS 6817-7:2020 / АДБОУС 3000

Гүйцэтгэлийн аудит

Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчимд үндэслэсэн стандарт болон удирдамжийг тусгасан.

MNS 6817-8:2020 / АДБОУС 4000

Нийцлийн аудит

Нийцлийн аудитын тулгуур зарчимд үндэслэсэн стандарт болон удирдамжийг тусгасан.

МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН 2018 ОНЫ ТӨРӨГӨД ОГУУЛГАЛЫН ТӨЛӨӨЛӨГӨСӨНИЙ СЭРЭГЭЖИЛТ ҮР ДЭЛ ҮР АЛШЫГ ГҮЙЛЭГЭЭЛЭЙН АГУУЛГАЛЫН ТӨЛӨӨЛӨГӨС

Төлбөрийн акт

Тоо: 1,934
Дун: 43.1 тэрбум төгрөг

Хэрэгжсэн

18.0 тэрбум ₮

₮12.8 их наяд
төгрөгийн 22,539 алдаа, зөрчил илрүүлж
үнээс 4.6 их наяд төгрөгөө үнэн дүн
бүхий 4,501 алдаа, зөрчлийг аудалын явцад
илрүүлсэн.



Албан шаардлага

Тоо: 3,313
Дүн: 2,297.7 тэрбум төгрөг

Хэрэгжсэн
421.9 тэрбум ₮

Зөвлөмж

Тоо: 9,890
Дүн: 3,838.0 тэрбум төгрөг

Хэрэгжсэн
2,917.8 тэрбум ₮

₮40.1 тэрбум

региог улс, орон нутгийн төсөвт
алерүүлсэн

₮359.6 тэрбум

төгрөгийн үр өгөөжийг харилцагч
байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлсэн



2020 ОНД ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТЫН ҮР ДҮН



МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН 2
МУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ
"АШИГ" ГҮЙЦЭТГЭЛИЙН АУ

АУДИТЫН ХРОНИКА

9

Шинэ, өөрчлөгдсөн
80.6 тэрбум төгрөг
Төсвийн төсөвт

МОНГОЛ УЛСЫН 20
ХИНСЭН АУДИТЫН

МОНГОЛ УЛСЫН 20
ХИНСЭН АУДИТЫН

МОНГОЛ УЛСЫН 20
ХИНСЭН АУДИТЫН

МОНГОЛ УЛСЫН 20
ХИНСЭН АУДИТЫН



ГҮЙЦЭТГЭЛИЙН
АУДИТЫН ТАЙЛАН



2020

Хөвсгөл
Төрийн АУ

БАЙГУУЛЛА
ОРЧИН
ШИНЭТ

ХУРААНГУЙ ТОЙМ

Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2019 оны 05, 2020 оны 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторын 2019 оны А/100, 2020 оны А/53 дугаар тушаалаар Төрийн аудитын байгууллагын 2020 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэв.

Төрийн аудитын байгууллага 2020 онд 4141 аудитыг гүйцэтгэж, бүх шатны төсөв захирагчийн төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн тайланд 3825 дүгнэлт гаргасан. 160 гүйцэтгэлийн аудитад 6889 байгууллага, нэгжийн үйл ажиллагаа, 156 нийцлийн аудитад 14660 хуулийн этгээд, тэдгээртэй холбогдох талуудын үйл ажиллагааг тус тус хамруулсан байна. (Дүрслэл 1)

Гүйцэтгэсэн аудитын дүнгээр нийт 12,848.7 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 4,653.7 тэрбум төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, нийт 43.1 тэрбум төгрөгийн зөрчилд 1934 төлбөрийн акт тогтоож, 2,297.6 тэрбум төгрөгийн зөрчилд 3313 албан шаардлага хүргүүлж, 3,838.0 тэрбум төгрөгийн зөрчилд 9890 зөвлөмж өгсөн байна. (Дүрслэл 2)


Аудитын дүнд нийт илрүүлэлтийн 58.1 хувь буюу 7,461.4 тэрбум төгрөгийг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай, 19.2 хувь буюу 2,466.7 тэрбум төгрөгийг улс, орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлттэй, 8.1 хувь буюу 1,037.9 тэрбум төгрөгийг дотоод хяналт, хариуцлагатай холбоотой, 5.4 хувь буюу 700.0 тэрбум төгрөгийг хууль, тогтоомжийн хэрэгжилттэй, 9.2 хувь буюу 1,182.7 тэрбум төгрөгийг бусад асуудалтай холбоотой алдаа зөрчил эзэлж байна.

Аудитын үр дүнгийн үзүүлэлт

Дүрслэл 1. Гүйцэтгэсэн аудит




Дүрслэл 2. Аудитын илрүүлэлт




- Санхүүгийн тайлангийн аудит
- Гүйцэтгэлийн аудит
- Нийцлийн аудит

Дүрслэл 4. Гүйцэтгэсэн аудит (тоон харьцуулалт)




Дүрслэл 5. Аудитын үр нөлөө




Дүрслэл 6.

Төлбөрийн акт (тэрбум төгрөг)




Дүрслэл 7.

Албан шаардлага (тэрбум төгрөг)




Дүрслэл 3. Батлагдсан сэдэв (ГА, НА)




- Нэгдсэн удирдамжаар
- УИХ, аймаг нийслэлийн ИТХ-ын хүсэлтээр
- Өөрсдийн санаачилгаар
- Өргөдөл, гомдлын дагуу

Нийцлийн аудит




Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн орлого (тэрбум төгрөг)



Дүрслэл 8.

Зөвлөмж (тоо)



Батлагдсан сэдвийн хүрээнд нэгдсэн удирдамжаар 179, УИХ, аймаг, нийслэлийн ИТХ-ын захиалгаар 45, өөрийн санаачилгаар 89, өргөдөл гомдлын дагуу 3, нийт 316 гүйцэтгэлийн болон нийцлийн аудитыг гүйцэтгэсэн байна. (Дүрслэл 3)

Санхүүгийн тайлангийн болон гүйцэтгэл, нийцлийн аудитын 5 жилийн харьцуулсан үзүүлэлтийг харууллаа. (Дүрслэл 4)

Тайлант хугацаанд улс, орон нутгийн төсөвт 40.1 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, аудитад хамрагдсан байгууллагаас 359.6 тэрбум төгрөгийн үр өгөөжийг хүлээн зөвшөөрсөн нь төсвөөс авсан “Нэг” төгрөгийн санхүүжилт тутамд 18.6 төгрөгийн үр өгөөжийг бий болгосон байна. (Дүрслэл 5)

Монгол Улсын нэгдсэн төсвийн болон орон нутгийн төсвийн төсөлд санал өгөх чиг үүргийн хүрээнд 2020 онд орлого нэмэгдүүлэх чиглэлээр нийт 108 асуудал бүхий 138.7 тэрбум төгрөгийн, зардал бууруулах чиглэлээр 103 асуудлаар 134.9 тэрбум төгрөгийн санал боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлсэн бол орлого нэмэгдүүлэх чиглэлээрх 24.7 тэрбум төгрөгийн 72, зардал бууруулах чиглэлээрх 41.1 тэрбум төгрөгийн 55 санал холбогдох шатны төсвийн хэлэлцүүлгийн явцад хэрэгжсэн байна.

Төлбөрийн акт: Тайлант онд 43.1 тэрбум төгрөгийн 1934 төлбөрийн акт тогтоосноос 17.9 тэрбум төгрөгийг, өмнөх оны үлдэгдлээс 3.5 тэрбум төгрөгийн төлбөрийн актыг тус тус барагдуулж, тайлант хугацааны эцэст 34.0 тэрбум төгрөгийн 518 төлбөрийн актын үлдэгдэлтэй байна. (Дүрслэл 6)

Албан шаардлага: Тайлант онд 2,297.6 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах 3313 албан шаардлага хүргүүлснээс 421.9 тэрбум төгрөгийн 2851, өмнөх оны үлдэгдлээс 764.0 тэрбум төгрөгийн 497 албан шаардлага хэрэгжиж, тайлант хугацааны эцэст 2,987.0 тэрбум төгрөгийн 609 албан шаардлага дараа онд шилжиж байна. (Дүрслэл 7)

Зөвлөмж: Гүйцэтгэсэн аудитын дүнд үндэслэн шалгагдагч этгээд болон хамрагдагч талуудад 9890 зөвлөмж хүргүүлснээс хэрэгжилт 87.5 хувь буюу 8652, өмнөх оноос шилжиж ирсэн зөвлөмж 88.1 хувь буюу 1507 зөвлөмж хэрэгжиж, 2021 онд 1434 зөвлөмжийн хэрэгжилтэд аудитын мөрөөр гүйцэтгэх үе шатны ажлыг гүйцэтгэнэ. (Дүрслэл 8)

Тайлант хугацаанд ТАБ-аас гүйцэтгэлийн болон нийцлийн аудитын хүрээнд гүйцэтгэхээр төлөвлөсөн 24 багц сэдвийн аудитыг дуусгасан бол 11 аудит хойшилсон нь Ковид-19 цар тахлын улмаас буюу шалгагдагч этгээд болон аудитад хамрагдагч этгээдийн үйл ажиллагаа, хөл хорионы бэлэн байдлын зэрэглэлд шилжсэнтэй холбоотой байна.




САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудит нь шалгагдагч этгээд санхүүгийн тайлангаа холбогдох хууль тогтоомж, стандарт, захиргааны хэм хэмжээний болон


бусад эрх зүйн актын шаардлагад нийцүүлэн үнэн зөв, шударгаар тайлагнасан эсэхэд аудит хийж баталгаажуулж байна.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хамрагдсан байгууллага



Аудитын санал дүгнэлт



Аудитын илрүүлэлт - 9,365.7 тэрбум төгрөг



- Төлбөрийн акт - 21.4 тэрбум төгрөг
- Албан шаардлага - 1,898.2 тэрбум төгрөг
- Зөвлөмж - 2,788.9 тэрбум төгрөг
- Хариуцлага тооцуулах санал - 2.0 тэрбум төгрөг
- Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн - 1.5 тэрбум төгрөг



31
Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал



496
Хариуцлага тооцуулсан албан тушаалтан

■ Эхний үлдэгдэл ■ Тайлант хугацаанд тогтоосон ■ Хэрэгжсэн ■ Дараа онд шилжих үлдэгдэл



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ДҮН

Төрийн аудитын байгууллага хуулиар тодорхойлсон чиг үүргийнхээ дагуу улс, орон нутгийн төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөл хөтөлбөрийн 6542 санхүүгийн тайланд аудит хийснээс 3825 санхүүгийн тайланд бие дааж аудитын дүгнэлт гаргаж, 387 байгууллагад итгэл үзүүлж, 2311 тайланг түүвэрт хамруулжээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар 3825 байгууллагын санхүүгийн тайланд өгсөн санал дүгнэлтийн 3386 буюу 88.5 хувийг зөрчилгүй, 398 буюу 10.4 хувийг хязгаарлалттай, 24 нь сөрөг санал дүгнэлт өгч, 16 тайланд дүгнэлт гаргахаас татгалзсан байна.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар нийт 9,365.7 тэрбум төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 4,653.7 тэрбум төгрөгийн алдаа зөрчлийг санхүүгийн тайланд залруулсан байна. Аудитаар залруулагдаагүй 4,712.0 тэрбум төгрөгийн 12058

зөрчилд 21.4 тэрбум төгрөгийн төлбөрийн акт, 1,898.2 тэрбум төгрөгийн албан шаардлага өгч, 7156 зөрчилд зөвлөмж, 460 зөрчилд хариуцлага тооцуулах санал хүргүүлж, 31 зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.

Тайлант онд өгсөн 7156 зөвлөмж болон өмнөх оны үлдэгдэл 602, нийт 7758 зөвлөмжийн 95.5 хувь хэрэгжиж 349 зөвлөмжийн үлдэгдэлтэй гарлаа.

Тайлант онд тогтоосон 21.4 тэрбум, өмнөх оны үлдэгдэл 6.1 тэрбум, нийт 27.5 тэрбум төгрөгийн төлбөрийн актаас 14.1 тэрбум төгрөгийн актыг барагдуулж, 13.1 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.


Мөн тайлант онд өгсөн 1,898.2 тэрбум, өмнөх оны үлдэгдэл 494.4 тэрбум, нийт 2,392.6 тэрбум төгрөгийн албан шаардлагаас 702.3 тэрбум төгрөгийг хэрэгжүүлж, 1,689.5 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ҮР НӨЛӨӨ

- Төрийн байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах, аудитын түүвэрт хамрагдалтыг өмнөх оноос 11.7 хувиар нэмэгдүүлснээр төсвийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалт, хамгаалалтад тавих хяналт сайжирч, санхүүгийн сахилга хариуцлага дээшилж байна.
- Төрийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд аудит хийж дүгнэлт гаргах тоог нэмэгдүүлснээр аж ахуйн нэгжийн ашигт ажиллагаа дээшлэх, хөрөнгийн зарцуулалтын үр нөлөө нэмэгдэх, холбогдох дээд шатны байгууллагуудаас гаргаж буй шийдвэр, зохицуулалтад тавих хяналт сайжирч байна.
- Төрийн аудитын байгууллагаас төрөлжсөн аудитаар стандарт, хууль тогтоомж, дүрэм, заавар, салбарын онцлогийг тусгасан иж бүрэн Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг боловсруулж, мөрдөх зөвлөмжийг өгч ажилласнаар төсвийн байгууллагуудын санхүүгийн тайлагнал, тэдгээрийн үр дүнгийн үзүүлэлт үнэн зөв илэрхийлэгдэхэд зохих үр нөлөө үзүүлсэн байна.
- Төсвийн ил тод байдалд ахиц гарч байгаа боловч төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэл, тайлагнал сайжрахгүй байгаад дүгнэлт хийж, төсвийн зарцуулалтын хяналт, түүнд иргэд олон нийтийн оролцоог сайжруулахыг төрийн бүх байгууллагуудад аудитын дүнд үндэслэн зөвлөмж болголоо.

ЗАСГИЙН ГАЗРЫН 2019 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТ

Төсвийн ерөнхийлөн захирагч (55)



6,096.5 тэрбум төгрөг
Улсын ТЭЗ нийт алдаа зөрчил



3,119.7 тэрбум төгрөг
Улсын ТЭЗ залруулсан алдаа



303.9 тэрбум төгрөг
Улсын ТЭЗ алдаа зөрчил



2449
Улсын ТЭЗ зөвлөмж



593.0 тэрбум төгрөг
Орон нутгийн ТЭЗ нийт алдаа зөрчил



4537
Орон нутгийн ТЭЗ зөвлөмж

Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг баталгаажуулах аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2-т заасан хугацаанд гүйцэтгэж, Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 55 ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тэдгээрийн харьяа 4,470 төсвийн байгууллага, 370 төрийн сан, Засгийн газрын

22 тусгай сан, 549 төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, 134 төсөл хөтөлбөр, 997 орон нутаг дахь сангууд, хөрөнгө оруулалт болон зардлын санхүүгийн тайлан нийт 6542 санхүүгийн тайланг нэгтгэсэн байна.


Дүгнэлтийн гол үндэслэл нь зээл, тусламжаар хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн хүрээнд бий болсон 338.6 тэрбум төгрөгийн хөрөнгийг санхүүгийн тайланд тусгаагүй, дампуурсан банк, хадгаламж зээлийн хоршооноос авах 437.6 тэрбум төгрөгийн найдваргүй, дамжуулан зээлийн 593.3 тэрбум, Засгийн газрын тусгай сангуудын 138.6 тэрбум төгрөгийн эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдэлтэй, гадаад зээлийн эх үүсвэрээс дамжуулан зээлдүүлсэн 649.5 тэрбум төгрөгийн зээлийг 35 байгууллага, нэгж санхүүгийн тайланд өглөгөөр бүртгээгүй байна.

Аудитаар нийт 2,247.5 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 761.8 тэрбум төгрөгийн алдааг залруулж, 1,483.0 тэрбум төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 2.5 тэрбум төгрөгийн зөрчилд 8 зөвлөмж өгсөн байна.

Монгол Улсын Ерөнхий сайдад 3, Сангийн сайдад 4 зөвлөмж буюу төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн өмч хөрөнгийн зарцуулалт, санхүүгийн тайлагнал, гадаадын зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт, түүний тайлагналын асуудлаар шинэтгэл хийхийг зөвлөмж болгосон байна.




Монгол Улсын Их Хурлын анхааралд,

- **Монголбанкнаас арилжааны банкнуудад хийсэн эрсдэлийн үнэлгээ, хяналт шинжилгээний дүнд үндэслэн төрийн мөнгөн хөрөнгийг эрсдэлээс хамгаалах бодлого боловсруулах үүргийг холбогдох байгууллагад өгч, хэрэгжилтийг хангуулах асуудлыг толилуулсан байна.**



МОНГОЛ УЛСЫН 2019 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТ

Аудитын үр дүн

	12,040.3 тэрбум төгрөг Нийт орлого ба тусламж
	11,661.7 тэрбум төгрөг Нийт зарлага ба цэвэр зээл
	5 Зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2 дахь заалтын дагуу Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийх аудитыг төлөвлөсөн цаг хугацаанд нь гүйцэтгэж тайланг хуулийн хугацаанд УИХ-д хүргүүлэв.

Засгийн газраас тайлагнасан нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн нийт орлого ба тусламжийн 12,040.3 тэрбум, нийт зарлага ба цэвэр зээлийн 11,661.7 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийг аудитаар баталгаажууллаа.

Өмнөх оны зөвлөмжийн биелэлтийг аудитын явцад хянаж үзэхэд хэрэгжилт 65.0 хувьтай байгаа нь төсвийн бодлого, түүний хэрэгжилт сайжрах боломжийг алдсан байна гэж дүгнэв.

Тайланг хугацааны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 756.2 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч ДНБ-ий 2.0 хувьтай тэнцүү, батлагдсан үзүүлэлтээс 3.4 нэгж хувиар буурч, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагыг хангаж байгаа ч дараах асуудлыг хариуцсан байгууллагуудын анхааралд хандуулсан. Тухайлбал,


- Орлогын өсөлтийн хурд саарсан, зарлагын өсөлтийн хурд идэвхжих хандлагатай,
- Макро түвшний судалгаа, зах зээлийн гадаад, дотоод хүчин зүйлсийн үндэслэлийг бодитой тооцоолж, тусгаагүйгээс батлагдсан төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтэд өөрчлөлт оруулсан, төсвийн төлөвлөлтөд 3, гүйцэтгэлээр 1 үзүүлэлтийг тус тус хангаагүй,

- ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн талаарх төлөвлөлт, гүйцэтгэл нь шийдвэр гаргалтад ашиглах ач холбогдол багатай, үр дүнгийн шалгуур үзүүлэлт тохиромжгүй, зарим хүрэх үр дүнгийн хэрэгжих хугацаа, өртгийн тооцоо хангалтгүй байжээ.

Аудитаар үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх Монгол Улсын Ерөнхий Сайдад 3, Сангийн сайдад 2 зөвлөмж өглөө.

Монгол Улсын Их Хурлын анхааралд,

- *Монгол Улсын нэгдсэн төсвийн хүрээний мэдэгдэл, тухайн жилийн төсвийн тухай хуулийг хэлэлцэж, батлахдаа төсвийн тогтвортой байдлыг хангах хуулийн шаардлагыг баримталж, өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үндэслэлгүйгээр нэмэгдүүлэн, өөрчлөлт хийхгүй байх.*
- *Засгийн газар ба орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын төсвийн эрх мэдлийн хуваарилалтыг нэгдмэл зохицуулалтад оруулж эрх зүйн орчныг сайжруулах.*
- *ТЕЗ-д өгсөн аудитын зөвлөмжийн хэрэгжилт, дүнг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороогоор хэлэлцүүлэн төсвийн сахилга бат, хариуцлагыг сайжруулах чиглэлээр тодорхой шийдвэр гаргуулах саналыг толилуулав.*



МОНГОЛ УЛСЫН 2021 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГСӨН САНАЛ ДҮГНЭЛТ

“МУЕА-ын А/74 тушаалаар баталсан “Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт гаргах” ажлын хэсэг “Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагуудыг хангаж буй эсэхийг судлах”, “Төсвийн тэнцвэржүүлсэн төслийн тэнцэлд дүн шинжилгээ хийж, санал боловсруулах”, “Төслийн холбогдох үзүүлэлтүүдийг 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэлтэй харьцуулан дүгнэх”,

“Төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргах” чиглэлээр санал боловсруулж ажиллалаа.

Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн төсөлд төсвийн үр ашгийг сайжруулах дараах асуудлыг дүгнэлтэд тусгасан байна. Тухайлбал:

- Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т заасны дагуу төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх, зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх хүрээнд төрийн өмчит аж ахуйн нэгжүүдээс төвлөрүүлэх ногдол ашгийг 100.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх;
- Өрийн үйлчилгээний төлбөрийн төсөвт ирэх ачааллыг бууруулах;
- Төсвийн орлого бүрдэхэд хүндрэлтэй, гадаад өрийн дарамттай үед эрүүл мэнд, боловсрол, онцгой байдал, цагдаа, хил, гааль, мэргэжлийн хяналт зэрэг байгууллагуудаас бусад байгууллагын эд хогшил, тээвэр шатахуун, томилолт, зочин төлөөлөгчийн зардал зэрэг тэвчиж болох зардлуудыг 20 хүртэл хувиар бууруулах.

Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн төсөлд Төсвийн тусгай шаардлага, төсвийн хүрээний мэдэгдэл, Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламж, нийт зарлага ба цэвэр зээл, тэнцвэржүүлсэн тэнцлийн асуудлаар санал дүгнэлтийг тайланд тусгав.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ХҮРЭЭНД ГҮЙЦЭТГЭСЭН ЗАРИМ АУДИТЫН ДҮН



Улсын Их Хурлын ТБХ-ны 2019 оны 05 дугаар тогтоолын дагуу гүйцэтгэх ажил эрхэлдэг байгууллагын хөрөнгийн зарцуулалтад аудит хийх журмыг боловсруулан баталсны дагуу аудитыг гүйцэтгэж, тайлан дүгнэлтийг холбогдох газруудад хүргүүлсэн.



“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд МУЕА-ын тушаалаар баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудит хийлээ. Аудитаар нийт 1,668.8 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 294.1 тэрбум төгрөгийн алдааг залруулж, 914.0 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх 2 албан шаардлага хүргүүлж, 1,373.8 тэрбум төгрөгийн алдаа зөрчилд 15 зөвлөмж өгч, “Хязгаарлалттай” санал дүгнэлт гаргалаа.



УИХ-ын 2020 оны сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын эцсийн тайланг хянаж, дүнг олон нийтэд мэдээлэх аудитын хүрээнд тайлан ирүүлсэн нийт 29 тойрогт нам, эвслээс болон бие даан нэр дэвшсэн 470 нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянаж баталгаажууллаа.

УИХ-ын ээлжит сонгуульд нэр дэвшигчдээс сонгуулийн зардлын тайлангаа ирүүлсэн 470 нэр дэвшигчийн дансанд нийт 66.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрч, сонгуулийн үйл ажиллагааны зардалд 67.2 тэрбум төгрөг зарцуулж, харилцах дансанд 852.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй, 1.3 тэрбум төгрөгийн төлөгдөөгүй өр төлбөр тайлагнасан байна.

Аудитын хуулийн этгээд нь МУЕА-ын 2020 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн А/55 дугаар тушаалаар баталсан “Сонгуулийн зардлыг тайлагнах заавар, аргачлал”-ын дагуу аудит хийж баталгаажуулсныг дахин хянаж аудитын явцад нийт 2.8 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, тайлагналтай холбоотой 0.8 тэрбум төгрөгийн алдааг залруулсан байна.



“Монголын Үндэсний Олимпын хорооны үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитыг хийх төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитыг гүйцэтгэж, тайланг Монгол Улсын Ерөнхийлөгч болон холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

Төрийн аудитын байгууллага шалгагдагч этгээдийн бодлого, тогтолцоо, үйл ажиллагаа, чиг үүргийн хэрэгжилт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний үйл явц, үр дүн, арвилан хэмнэлттэй,

үр ашигтай, үр нөлөөтэй эсэхэд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт зөвлөмж гарган тайлагнаж байна.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ



160
Аудит
гүйцэтгэсэн



6889
байгууллагыг хамруулсан
(давхардсан тоогоор)



- Төлбөрийн акт - 6.2 тэрбум төгрөг
- Албан шаардлага - 287.0 тэрбум төгрөг
- Зөвлөмж - 986.3 тэрбум төгрөг
- Хариуцлага тооцуулах санал - 7.7 тэрбум төгрөг
- Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн - 2,002.6 тэрбум төгрөг




1106
Зөвлөмж



21
Хууль, хяналтын
байгууллагад
шилжүүлсэн асуудал



27
Хариуцлага
тооцуулсан албан
тушаалтан



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ҮР ДҮН

Төрийн аудитын байгууллагаас 2020 онд баталсан аудитын сэдэв, төлөвлөгөөний хүрээнд 160 аудитыг 6889 /давхардсан тоогоор/ байгууллагыг хамруулан хийлээ.

Гүйцэтгэлийн аудитаар нийт 3,289.8 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлж 6.2 тэрбум төгрөгийн 169 зөрчилд төлбөрийн акт, 287.0 тэрбум төгрөгийн 328 зөрчилд албан шаардлага, 986.3 тэрбум төгрөгийн 1106 зөрчилд зөвлөмж өгсөн бол 7.7 тэрбум төгрөгийн 31 зөрчилд хариуцлага тооцуулах санал хүргүүлж, 2,002.6 тэрбум төгрөгийн 21 зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ҮР НӨЛӨӨ

- ТАБ-ын бодлогоор уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн өмчит компаниудын үйл ажиллагаа, төрөөс сургуулийн өмнөх боловсрол олгож байгаа байдал, нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн аудитаар, төрөөс баримталж буй бодлогын хэрэгжилтийн үр нөлөөг үнэлж, хууль, эрх зүйн орчин, тогтолцоог сайжруулах зөвлөмж хүргүүлэв.
- Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж, хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход анхаарч ажиллалаа.
- Улсын хэмжээнд гүйцэтгэж буй хөрөнгө оруулалтын шинж чанартай томоохон төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт болох газрын тос боловсруулах, нисэх буудал, цахилгаан станц, төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын “барих-шилжүүлэх” төрлөөр гэрээ байгуулсан арга хэмжээний хүрээнд цахилгааны дэд станц, цэцэрлэг, авто замын нийт 7 төслийн хэрэгжилтэд аудит хийж, гүйцэтгэл, гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах, төслийг цаг хугацаанд нь үр нөлөөтэй хэрэгжүүлэхийг холбогдох байгууллагуудад зөвлөмж болголоо.
- Гүйцэтгэлийн аудитын хүрээнд илэрсэн алдаа зөрчил нь хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхдээ үйл ажиллагааны үр дүн, үр нөлөө, арвилан хэмнэлт, үр ашгийг тооцож ажиллахгүй байгааг шалгагдагч болон хамрагдагч этгээдэд анхааруулан зөвлөж ажиллалаа.

Гүйцэтгэлийн аудитын үр нөлөөг сайжруулахын тулд тухайн сэдвээр аудит хийх урьдчилсан судалгааны ажилд зарцуулах хугацааг зохистой болгон төрийн аудитын стандартын зарчмыг баримтлан улсын хэмжээнд хэрэгжүүлж буй томоохон төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үйл

Төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэлийн аудитаар тайлант онд өгсөн 1106 зөвлөмж, өмнөх оны үлдэгдэл 888, нийт 1994 зөвлөмжийн 65.6 хувийг хэрэгжүүлж, 681 зөвлөмж хэрэгжих шатанд байна.

Тайлант онд өгсөн 287.0 тэрбум, өмнөх оны үлдэгдэл 1,308.5 тэрбум, нийт 1,595.5 тэрбум төгрөгийн албан шаардлагаас 388.1 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгаж, 1,207.1 тэрбум төгрөгийн албан шаардлагын үлдэгдэлтэй байна. Тайлант онд 2.1 тэрбум төгрөгийг улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

ажиллагааны эрсдэлийг бууруулсан зардлын хязгаарлалттай, сөрөг үр дагавар багатай, хэрэгжихэд дэмжлэг болохуйц бодит хугацааны чанартай аудит гүйцэтгэхийг анхаарлынхаа төвд байлгахыг зорьж байна.

УЛСЫН ТӨСВИЙН 2019 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ

Аудитын үр дүн



4.8 тэрбум төгрөг
Төлбөрийн акт



103.3 тэрбум төгрөг
Албан шаардлага



9
Зөвлөмж

Аудитыг нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрөөр гүйцэтгэж, Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулиар баталсан 25 ТЕЗ-ийн төсвийн багцын 3,200.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1,553.4 тэрбум төгрөгийн санхүүжих дүн бүхий 1281 ТАХ-ний төлөвлөлт, хэрэгжилтэд ТЕЗ-д, түүний харьяа байгууллага, Сангийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Барилгын хөгжлийн төв, эрх хүлээн авсан аймаг, нийслэлийн ЗДТГ, техник хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагууд, ажил гүйцэтгэгч зарим ААН-ийн үйл ажиллагааг хамруулан аудит хийв.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/54 дүгээр тушаалаар аудитын тайланг эцэслэн баталгаажуулж, УИХ-ын Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо, ЗГХЭГ, Сангийн яаманд тус тус хүргүүлсэн болно.



НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН /2012-2016 ОН/

Аудитад Сангийн яам, ХНХЯ, ЭМЯ, НДЕГ, НДҮЗ, орон нутаг дахь нийгмийн даатгалын газар, хэлтэс, ЭМДЕГ, ЭМДҮЗ-ийн 2012-2018 оны үйл ажиллагааг хамруулан, нэгдсэн удирдамжаар гүйцэтгэсэн бөгөөд аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн “Нийгмийн даатгалын сангийн бодлогыг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, бие даасан байдлыг хангах шаардлагатай байна” гэсэн дүгнэлт гаргалаа.


“Улсын Их Хурал, Засгийн газраас гаргасан шийдвэрийн үр нөлөөний улмаас Тэтгэврийн даатгалын сан алдагдалд орох нөхцөл бүрдэж, “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын 2.2-т заасан сангийн бие даасан байдлыг сайжруулах бодлого

Аудитаар “Хариуцлагын тогтолцоо сул байгаагаас төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилтэд хууль, эрх зүйн зохицуулалт зөрчигдсөөр байна” гэсэн дүгнэлт өгсөн бөгөөд төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналын зөрчлүүдтэй холбогдуулан дүгнэлт гаргаж, Улсын Их Хурлын анхааралд 1 асуудлыг толилуулсан болно.

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар Монгол Улсын Ерөнхий сайдад 3, Сангийн сайдад 2, Төсвийн ерөнхийлөн захирагч нарт 4, нийт 9 зөвлөмжийг өгчээ.


Монгол Улсын Их Хурлын анхааралд,

- *Улсын төсвөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдтэй нийцүүлэн баталж, салбарын төвшинд төлөвлөөгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг хуульд тусгаж буй зөрчлийг давтан гаргахгүй байх чиглэлээр эрх зүй, хариуцлагын тогтолцоог бүрэн бүрдүүлэхэд анхаарч ажиллахыг толилуулж байна.*



хэрэгжихгүй байна” зэрэг голлох асуудлуудыг хөндсөн 14 зүйл бүхий дүгнэлтийг гаргаж, холбогдох байгууллагад 8 зөвлөмж хүргүүлэв.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/22 дугаар тушаалаар аудитын тайланг баталгаажуулж, УИХ-ын Төсвийн байнгын хороо, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт тус тус хүргүүлсэн байна.






ТӨРӨӨС СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ ОЛГОЖ БАЙГАА ӨНӨГИЙН БАЙДАЛ, ҮР ДҮН

Аудитын тайланг Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/13 дугаар тушаалаар баталгаажуулан УИХ-ын Төсвийн байнгын хороо, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Сангийн яам, Барилга, хот байгуулалтын яам болон холбогдох бусад байгууллагад хүргүүлэв.

Аудитыг нэгдсэн удирдамжаар гүйцэтгэсэн бөгөөд аудитын дүнд үндэслэн 6 зүйл бүхий дүгнэлт гаргаж, “Хамран сургалт нэмэгдэж байгаа боловч төрийн өмчийн зарим цэцэрлэгийн нэг бүлгийн хүүхдийн тоо хүчин

чадлаас хоёр дахин хэтэрсэн, сургалтын чанарыг үнэлж дүгнэх боломж бүрдээгүй байна” гэсэн дүгнэлт өглөө.

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдад 2, Сангийн сайдад 2, Барилга, хот байгуулалтын сайдад 1, Нийслэлийн ИТХ-д 1, БСШУСЯ-ны холбогдох газар, нэгжийн удирдлагад 1, нийт 7 зөвлөмж өгсөн байна.



“МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2019 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ”

Аудитын үр дүн



76.9%

Үндсэн чиглэлийн биелэлт



7

Зөвлөмж

УИХ-ын 2018 оны 37 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн төлөвлөгөөнд тусгагдсан 135 зорилт, арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх, биелэлтийн явц, үр дүнг тооцон тайлагнах үүрэг хүлээсэн Төрийн захиргааны 22 төв байгууллага, агентлагийг хамрууллаа.


“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй буюу биелэлт 76.9 хувьтай байна” гэсэн ерөнхий дүгнэлт өгч, эрх зүйн зохицуулалттай холбоотой 2 асуудлыг УИХ-ын анхааралд толилуулж, үндсэн чиглэлийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах, үр дүнг үнэлэх үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах чиглэлээр ЗГХЭГ-т 2, Сангийн сайдад 1, ТЕЗ нарт 3, Монголбанканд 1, нийт 7 зөвлөмж өгсөн байна.

МУЕА-ын 2020 оны А/37 дугаар тушаалаар аудитын тайланг баталгаажуулж, УИХ-ын Эдийн

засгийн байнгын хороо, ЗГХЭГ, Сангийн яаманд тус тус хүргүүллээ.

Монгол Улсын Их Хурлын анхааралд,

- Засгийн газраас өргөн барьсан Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэлэлцэж шийдвэр гаргахдаа хууль, журмын дагуу нөхцөл байдлын урьдчилсан судалгаа хийгдээгүй, ТЭЗҮ, зураг, төсөлгүй, бэлтгэл ажил хангагдаагүй, санхүүжилтийн эх үүсвэргүй арга хэмжээг нэмж батлахгүй байх;
- УИХ-ын 2011 оны 34 дүгээр тогтоолын 2-т “Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлийн биелэлтэд гүйцэтгэлийн аудит хийж, аудитын тайланг Улсын Их Хуралд ирүүлж байхыг Үндэсний аудитын газарт үүрэг болгосугай” гэж заасныг эргэн хянаж, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.10 дахь заалттай уялдуулан ҮАГ-аас Засгийн газрын мөрийн хөтөлбөр буюу дунд хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд аудит хийх талаар эрх зүйн зохицуулалттай болгох асуудлыг тус тус толилуулж байна.





ХӨШИГИЙН ХӨНДИЙН ОЛОН УЛСЫН НИСЭХ БУУДЛЫН ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Аудитын тайланг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/35 дугаар тушаалаар баталгаажуулан УИХ-ын Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам болон бусад холбогдох байгууллагуудад хүргүүлэв.

Аудитад Хөшигийн хөндийн Олон улсын нисэх онгоцны буудал барих төслийн гэрээ хэлэлцээр, түүний хэрэгжилт, ЗТХЯ, Сангийн яам, төслийн зөвлөх болон ерөнхий, туслан гүйцэтгэгч компаниудыг хамрууллаа.


Аудитын дүнд үндэслэн 7 зүйл бүхий дүгнэлтийг гаргаж, "Төслийн цар хүрээ өргөжин зээлийн хэмжээ нэмэгдэж, олон улсын нисэх онгоцны шинэ буудал ашиглалтад орох хугацаа хойшилсон байна" гэсэн ерөнхий дүгнэлтийг өгсөн болно.

Аудитаар Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны анхааралд 1 санал толилуулж,

Монгол Улсын Ерөнхий сайдад 3, Сангийн сайдад 3, Зам, тээврийн хөгжлийн сайдад 2, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт 1, нийт 9 зөвлөмж хүргүүлсэн байна.

Улсын Их Хурлын Эдийн Засгийн Байнгын Хорооны анхааралд

- *Хууль тогтоомжоор шалгуур болгосон төсвийн зарчим, өрийн тусгай шаардлагын зохицуулалтыг тогтвортой байлгаж, цаашид гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх томоохон төсөл, хөтөлбөрийн зээлийн гэрээг иж бүрэн боловсруулсан эсэх, төсөв, мөнгөний бодлоготой уялдуулсан эсэхэд анхаарал хандуулахыг санал болгож байна.*



СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДОН УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛД АУДИТ ХИЙЖ ДҮГНЭЛТ ГАРГАХ

Аудитын үр дүн



744.8 сая төгрөг
Төлбөрийн акт



5
Зөвлөмж

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу сонгууль зохион байгуулахтай холбогдуулан улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж, тайланг МУЕА-ын 2020 оны А/103 дугаар тушаалаар баталгаажуулан УИХ болон холбогдох байгууллагуудад хүргүүлэв.

Аудитад СЕХ, аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороод, УБЕГ, ЦЕГ, ОБЕГ, ТЕГ, ТТХГ, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Үндэсний статистикийн хороо зэрэг байгууллагуудын улсын төсвөөс санхүүжсэн сонгуулийн зардлын төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналын үйл ажиллагааг хамруулан нийт 744.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, улсын төсөвт төвлөрүүлээ.

Аудитын дүнд үндэслэн "Сонгуулийн зардлын төлөвлөлт, зарцуулалтад тавих явцын хяналт хангалтгүй байна" гэсэн ерөнхий дүгнэлт өгч, Сонгуулийн ерөнхий хороонд 5 зөвлөмж хүргүүлсэн байна.

“ТАВАНТОЛГОЙН ЦАХИЛГААН СТАНЦ” БАРИХ ТӨСӨЛ БОЛОН ТӨСЛИЙН НЭГЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗОРИУЛАН ХӨГЖЛИЙН БАНКНААС ЭРГЭН ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛТЭЙ ОЛГОСОН ЗЭЭЛИЙН АШИГЛАЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН

Аудитын үр дүн




3
Зөвлөмж

“Тавантолгойн цахилгаан станц” барих төсөл болон төслийн нэгжийн үйл ажиллагаанд зориулан хөгжлийн банкнаас эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээлийн ашиглалт, зарцуулалт, үр дүн сэдэвт гүйцэтгэлийг аудитыг хийж, тайланг МУЕА-ын 2020 оны А/75 дугаар тушаалаар баталгаажуулан холбогдох байгууллагуудад хүргүүлэв.

ЭХЯ, Сангийн яам, “Тавантолгой цахилгаан станц” ХХК, Хөгжлийн банк, Тавантолгойн цахилгаан

станц барих төслийн нэгжийн 2013-2020 оны 1 дүгээр улирлын байдлаарх төсөлтэй холбоотой асуудлыг хамруулан гүйцэтгэж, аудитын дүнд үндэслэн “Тавантолгойн цахилгаан станц” төслийн үйл ажиллагаанд хууль тогтоомж, гэрээний хэрэгжилт хангалтгүй, зээлийн зарцуулалт үр дүнгүй болох эрсдэл байна гэсэн дүгнэлт гарган Сангийн сайдад 1, Эрчим хүчний сайдад 1, Хөгжлийн банканд 1, нийт 3 зөвлөмж хүргүүлсэн болно.



QR кодоор
тайланг
үзнэ үү.

УЛСЫН ТӨСВӨӨС ЭРГЭН ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛТЭЙ КОНЦЕССЫН “БАРИХ-ШИЛЖҮҮЛЭХ” ТӨРЛӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

“Баянхонгор аймгийн Өлзийт суманд 100 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөл барих төсөл”


Аудитын үр дүн



2
Зөвлөмж

Төслийн төсөвт өртгийг батлагдсан зураг төслийн дагуу зохиож, холбогдох хяналт нь барилгын салбарт мөрдөгдөж байгаа норм, дүрэм, зургийн даалгавар, техникийн нөхцөлийн шаардлагыг хангасан боловч эрх бүхий байгууллагаас концессын гэрээний хэрэгжилт, явцад бүрэн хяналт хийгээгүй, үүргээ

хэрэгжүүлээгүй, гэрээний хүчин төгөлдөр болох нөхцөл хангасан тухай дүгнэлтийг хугацаа алдаж баталгаажуулсан, гүйцэтгэгч барилга угсралтын ажлын дүнг 13.8 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, зарим ажлыг дутуу хийсэн зэрэг илэрсэн зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн байна.



“Аглаг бүтээлийн хийд хүртэлх 6.2 км авто замын төсөл”

Аудитын үр дүн




5
Зөвлөмж

Хөрөнгө оруулалтын зардал, ашгийн тооцоогүйгээр орон нутгийн чанартай авто замын төслийг төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад батлуулсан, хуульд заасан шаардлагыг хангаагүй байхад гүйцэтгэгчтэй “шууд гэрээ” байгуулж хэрэгжүүлсэн байна.

хэсэгт заасныг зөрчиж, концессын зүйлийг хэрэгжүүлж дуусаагүй байхад санхүүжилтийг олгожээ.

Концессын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь концессын гэрээний хэрэгжилтэд үнэлгээ хийх, хяналт тавих, гэрээний ашиглалт, төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг хугацаанд нь гаргуулан авч тайлагнах үүргээ хэрэгжүүлэхгүй байсан алдаа зөрчил илэрсэн байна.

Захиалагч болон санхүүжүүлэгч байгууллагууд УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоолын 1.7 дахь



“Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км хатуу хучилттай авто замын төсөл”

Аудитын үр дүн



3
Зөвлөмж

Гэрээт ажлын гүйцэтгэл бүрэн хангагдаагүй байхад эрх бүхий байгууллагаас томилсон улсын комисс “Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх,

ашиглалтад авах журам”-ын холбогдох заалтыг зөрчин авто замыг ашиглалтад хүлээн авсан, төсөвт зарим материалын орц нормыг буруу тооцсон зэрэг зөрчил илэрлээ.



ДАРАА ОНД ШИЛЖИЖ БУЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

Ковид-19 цар тахлын нөлөөллийн улмаас гүйцэтгэх боломжгүй болж тайлагнах хугацаа хойшилсон дараах аудит байна. Үүнд:

- Газрын тосны салбарт 2019 онд бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалт
- Газрын тосны салбарт 2019 онд бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалт-”Доншен газрын тос Монгол” ХХК-ийн 2019 оны өртөг нөхөх зардлын баталгаажуулалт
- Газрын тосны салбарт 2014-2019 онд бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалт-”Петрочайна дачин тамсаг Монгол” ХХК-ийн 2 талбайд өртөг нөхөх зардлын баталгаажуулалт

Хууль тогтоомжийн дагуу нэмэлтээр гүйцэтгэсэн, аудитын төлөвлөгөөний дагуу тайлагналын үе шат үргэлжлэн хэрэгжиж байгаа дараах аудит байна. Үүнд:

- Засгийн газраас агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр 2017-2020 онд зарцуулсан хөрөнгийн ашиглалт, үр нөлөө
- “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2018-2019 оны үйл ажиллагаа болон Тавантолгойн орд ашиглалтад Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, Ашигт малтмалын тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлт
- Засгийн газрын ойрын үед хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсвийн хөрөнгөөр болон төсвийн хөрөнгийн оролцоотой хэрэгжих төслийн ТЭЗҮ, байгуулах хөрөнгө оруулалтын гэрээнд аудит хийх-“Улаанбаатар-Дархан” чиглэлийн 204.6 км автозам төслийн хэрэгжилт, үр дүн
- Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн
- “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын үйл ажиллагааны үр дүн
- Оюутолгой төсөлд оруулсан хөрөнгө оруулалт, санхүүжилтийн зарцуулалт, үр нөлөө

АЙМАГ, НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ГҮЙЦЭТГЭСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ



Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагааны үр дүнд ажлын байр нэмэгдсэн байдал /Архангай аймаг дахь ТАГ/

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээний төсвийг зориулалтын дагуу зарцуулсан 4 сургалтын байгууллагуудтай байгуулсан гэрээг дүгнээгүй, сургалтад хөрөнгө зарцуулж байгаа боловч эцсийн үр дүн болох ажилгүй иргэн ажилтай болсон байх асуудал орхигдсон, Сангийн хөрөнгийн зарцуулалт, зээл, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн байдалд байгууллагын дотоод хяналт, шалгалт хийсэн боловч түүний мөрөөр үр дүнтэй арга хэмжээ аваагүй зэрэгтэй холбоотой алдаа зөрчил илэрсэн байна.

Аудитын дүнд үндэслэн “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангаас санхүүжүүлсэн төслүүд хэрэгжиж байгаа боловч төлөвлөсөн ажлын байрыг хангалттай бий болгоогүй байна” гэсэн дүгнэлт өгч 2 албан шаардлага, 9 заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн байна.



Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас олгосон зээлийн зарцуулалт, үр дүн /Баянхонгор аймаг дахь ТАГ/

ЖДҮДС-гаас 2019 онд хуваарилсан санхүүжилтээс 26 иргэнд олгосон 681.0 сая төгрөгийн зээлийн зарцуулалтыг бичсэн төсөлтэй харьцуулан шалгаж, ажлын байр нэмэгдсэн байдлыг газар дээр нь үзэж шалгасан байна.

салбарт хүргүүлэн ажилласан байна.

Тогтоосон төлбөрийн актын 76.4 хувь, албан шаардлагын 34.7 хувь хэрэгжиж, 2020 онд Ковид-19 цар тахалтай холбоотой хөл хорио тогтоосны улмаас бизнес эрхлэгч нар тоног төхөөрөмжөө аваагүй, үйл ажиллагаа эрхлээгүйтэй холбоотой төлбөрийн акт, албан шаардлагыг бүрэн биелүүлэх боломжгүй болсон тул дараа онд давтан аудит хийхээр шийдвэрлэсэн байна.


Төсөл сонгон шалгаруулах дэд хороо холбогдох журам, чиглэлийг баримталж ажиллаагүйгээс бусад санд хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй иргэн, ААН-д зээл давхардуулан олгосон, зарим зээлдэгч төсөлд заагдсан зориулалтын дагуу зээлийг ашиглаагүй, ажлын байрыг нэмэгдүүлээгүй зэрэг зөрчил илэрч, төлбөрийн 4 акт тогтоож, 7 албан шаардлага, 10 зөвлөмжийг аймгийн ХХААГ, Монгол банкны



Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр хураамжийн төлөвлөлт, бүрдүүлэлтийн үр дүн /Ховд аймаг дахь ТАГ/

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн “Зарим тусгай зөвшөөрлийг газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгахгүйгээр олгосон, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашиглах, төлбөр төлөх эрх зүйн зохицуулалт хангагдсан боловч, хуулийн хэрэгжилт хангалтгүй, түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөрийн гүйцэтгэлийн хяналт

хийгдээгүй тул үр нөлөөг тооцох боломжгүй байна” гэсэн ерөнхий дүгнэлт гарч, холбоотой талуудад зөвлөмж өгсөн байна.






Мал аж ахуйн салбарын бодлого, үйл ажиллагааны үр дүн /Дундговь аймаг дахь ТАГ/

Аудитын дүн, нотлох зүйлсэд үндэслэн “Мал аж ахуйн салбарт малчдын үүрэг хариуцлага, оролцоог нэмэгдүүлэх, байгаль орчин, бэлчээрийг хамгаалах бодлого зохицуулалтыг бий болгож, хэрэгжүүлэх шаардлагатай байна” гэж дүгнэсэн байна.

Малчид хээлтүүлэгч малаа ялгаж суурилагагүй, отор нүүдлээр явсан малчид мал эмнэлгийн гэрчилгээ авч бүртгүүлээгүй, малыг цахим бүртгэлд бүрэн хамруулаагүй, малын гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд ариун цэврийн

магадлан шинжилгээг тухай бүр хийгээгүй, мал эмнэлгийн гэрчилгээг тухай бүр олгоогүй зэрэг зөрчлүүд илэрч, аймгийн Засаг даргад 4, Хүнс, хөдөө аж ахуйн газарт 1, Мал эмнэлгийн газарт 2, нийт 7 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлжээ.




QR кодоор
тайланг
үзнэ үү.



Нийслэлийн төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг /Нийслэл дэх ТАГ/

- Нийслэлийн 2019 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг бодлогын баримт бичигтэй уялдуулж байгаа боловч зарим ажлын нэр төрөл, байршлаар нарийвчлан заалгүй арга хэмжээг төлөвлөсөн нь төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулсан байна.
- Төсөл, арга хэмжээний эрх шилжсэн хугацаанаас шалтгаалж зарим худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажил хойшлогдох, тухайн онд хэрэгжих боломжгүй болох зэргээр төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн, үр ашиг буурах шалтгаан болжээ.
- Төсөл, арга хэмжээний төлөвлөлт болон Нийслэлийн Засаг даргаас эрх шилжүүлэхдээ хугацаа алдаж байгаа нь ажлын эхлэх, дуусах хугацаанд нөлөөлсөн, зарим ажлын барилга угсралтын явцад тавих захиалагчийн хяналтыг мэргэжлийн байгууллага иж бүрэн хэрэгжүүлээгүй нь төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр дүн, үр ашгийг бууруулж байгаа шалтгааныг тус тус илрүүлжээ.

Аудитаар нийт 113.3 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс нийслэлийн ЗДТГ-ын даргад 99.3 тэрбум төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлж холбогдох байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж ажилласан байна.



QR кодоор
тайланг
үзнэ үү.

Хүснэгт 1 АНТАГ-уудын гүйцэтгэсэн Гүйцэтгэлийн аудитын сэдэв, ангиллаар

Д.д	Сэдвийн ангилал	Аймаг, нийслэлийн ИТХ-ын хүсэлтээр	Өөрийн санаачилгаар	Нийт
1	Төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, тусгай сангуудын үр дүн, зарцуулалттай холбоотой	4	25	29
2	Байгалийн нөөц, баялгийн ашиглалттай холбоотой	-	2	2
3	УИХ, ЗГ, ИТХ-аас батлагдсан төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилттэй холбоотой	2	3	5
4	Төрийн үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааны үр дүнтэй холбоотой	6	12	18
	Нийт	12	42	54



НИЙЦЛИЙН АУДИТ

Төрийн аудитын байгууллагын нийцлийн аудит нь шалгагдагч этгээдийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа төрийн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж, захиргааны

хэм хэмжээний болон бусад эрх зүйн актын хэрэгжилт, тэдгээрийн нийцэлд аудит хийж дүгнэлт, зөвлөмж гаргаж байна.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ



156
Аудит
гүйцэтгэсэн



14660
хамрагдагч этгээд
(давхардсан тоогоор)



- Төлбөрийн акт - 15.5 тэрбум төгрөг
- Албан шаардлага - 112.5 тэрбум төгрөг
- Зөвлөмж - 62.7 тэрбум төгрөг
- Хариуцлага тооцуулах санал - 0.7 тэрбум төгрөг
- Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн - 1.8 тэрбум төгрөг




1628
Зөвлөмж



20
Хууль, хяналтын
байгууллагад
шилжүүлсэн асуудал



37
Хариуцлага
тооцуулсан албан
тушаалтан



НИЙЦЛИЙН АУДИТЫН ҮР ДҮН

Төрийн аудитын байгууллагаас 2020 онд баталсан аудитын сэдэв, төлөвлөгөөний хүрээнд 156 аудитыг 14660 /давхардсан тоогоор/ байгууллага, шалгагдагч этгээдийг хамруулан гүйцэтгэв.

Нийцлийн аудитаар нийт 193.2 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 15.5 тэрбум төгрөгийн 102 зөрчилд төлбөрийн акт, 112.5 тэрбум төгрөгийн 475 зөрчилд албан шаардлага, 62.7 тэрбум төгрөгийн 1628 зөрчилд зөвлөмж өгсөн бол 0.7 тэрбум төгрөгийн 28 зөрчилд хариуцлага тооцуулах санал хүргүүлж, 1.8 тэрбум төгрөгийн 20 зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.

Нийцлийн аудитаар тайлант онд өгсөн 1628 зөвлөмж, өмнөх онуудын үлдэгдэл 221, нийт 1849 зөвлөмжийн 78.0 хувь буюу 1443 зөвлөмжийг хэрэгжүүлж, 399 зөвлөмжийн үлдэгдэлтэй байна.

Тайлант онд тогтоосон 15.5 тэрбум төгрөг, өмнөх оны үлдэгдэл 2.4 тэрбум төгрөг, нийт 17.9 тэрбум төгрөгийн актаас 4.0 тэрбум төгрөгийн актыг барагдуулж, 13.4 тэрбум төгрөгийн актын үлдэгдэлтэй байна.

Мөн тайлант онд өгсөн 112.5 тэрбум төгрөг, өмнөх оны үлдэгдэл 73.6 тэрбум төгрөг, нийт

186,1 тэрбум төгрөгийн албан шаардлагаас 2020 онд 95.5 тэрбум төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлж, 90.4 тэрбум төгрөгийн албан шаардлагын үлдэгдэлтэй байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулагдсантай холбогдуулан намуудын хандивын тайлан, мөрийн хөтөлбөр, сонгуулийн зардлын тайлан баталгаажуулах аудитыг хуулийн хугацаанд гүйцэтгэсэн байна.

“Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцохоо илэрхийлж бүртгүүлсэн улс төрийн нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн эсэх болон санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэж байгаа эсэх талаар дүгнэлт гаргах”-д 201 бие даан нэр дэвшигч, 15 нам, 4 эвсэл мөрийн хөтөлбөрөө ирүүлсэн бөгөөд 173 бие даан нэр дэвшигч, 15 нам 4 эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гарган хуульд заасан хугацаанд Сонгуулийн Ерөнхий хороонд хүргүүлэн ажиллав.

НИЙЦЛИЙН АУДИТЫН ҮР НӨЛӨӨ

- Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгууль зохион байгуулагдсантай холбогдуулан сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт аудит хийж, дүгнэлт гаргах аргачлалыг анх удаа боловсруулан холбогдох дүрэм, заавар аргачлалыг МУЕА-ын шийдвэрээр батлан мөрдөж, аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэлээ.
- Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцохоо илэрхийлж бүртгүүлсэн улс төрийн нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээг хэрэгжүүлэх зардлын дүн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцсэн эсэхэд дүгнэлт гаргаснаар Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заасан хууль дээдлэх болон шударга ёсыг сахих зарчим хангагдаж, иргэд хууль тогтоомжид нийцсэн мөрийн хөтөлбөрт үндэслэн саналаа өгөх боломж нөхцөл бүрдсэн байна.
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитын үр дүнд хуулийн хэрэгжилтэд олон нийт хяналт тавих боломж бүрдэж, хуульд зааснаар мэдээлэл ил тод мэдээлэгдсэнээр улс, орон нутгийн төсөв, өмч хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах хуулийн хэрэгжилт сайжирна.

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТ

Аудитын үр дүн



4352

Түүвэрт хамрагдсан байгууллага



332

Зөвлөмж

Аудитын төлөвлөгөөний дагуу улсын төсвийн 32 ТЕЗ, тэдгээрт хамаарах 265 байгууллага, аймаг нийслэлийн 22 ТЕЗ, тэдгээрт хамаарах 4087 байгууллага нийт 4352 байгууллагыг аудитын түүвэрт хамруулан, ШДНЦХ-т байршуулсан мэдээллийг төсөв, санхүүгийн холбогдох баримт, нотлох зүйлстэй тулган шалгаж, бусад 1458 байгууллага, мөн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-3.1.5-д хамаарах аж ахуйн нэгж, байгууллагыг ТЕЗ-даас ирүүлсэн дотоод хяналтын дүн мэдээ болон ШДНЦХ-т байршуулсан мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийж улсын хэмжээнд хуулийн хэрэгжилтийн дүнг гаргав.

Шилэн дансны тухай хуульд заасны дагуу төсвийн удирдлагыг хэрэгжүүлсэн шийдвэр, үйл ажиллагааны ил тод байдлыг 2019 онд улсын төсвийн ТЕЗ-д болон тэдгээрт хамаарах байгууллагууд 91.5 хувь, аймаг, нийслэлийн төсвийн ТЕЗ-д болон тэдгээрт хамаарах байгууллагууд 87.9 хувь хэрэгжүүлж ажилласан байна.




УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛЬД НАМ, ЭВСЭЛ, НЭР ДЭВШИГЧЭЭС ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫН ДЭЭД ХЭМЖЭЭГ ТОГТООХ АУДИТ

Аудитыг гүйцэтгэхэд шаардлагатай дагаж мөрдөх аргачлалыг боловсруулах ажлын хэсгийг байгуулж, МУЕА, СЕХ-ны даргын 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 04/А-16 дугаар хамтарсан шийдвэрээр “Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох аргачлал”-ыг анх удаа боловсруулж батлан хэрэгжүүллээ. УИХ-ын 2020 оны ээлжит сонгуульд нам, эвсэл,

Тус аудитад хамрагдсан байгууллагын төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагааны ил тод байдлыг хангахаар аудитын явцад залруулах боломжтой зөрчлийг тухай бүр арилгуулж, зөвлөмж өгч ажилласнаас гадна нийт 332 зөвлөмж өгч, 128 байгууллага, албан тушаалтанд зөрчил арилгуулах хугацаатай албан шаардлага хүргүүлж ажилласан байна.

Аудитын тайланг МУЕА-ын 2020 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн А/71 дугаар тушаалаар баталгаажуулж, Төсвийн байнгын хороо, ЗГХЭГ, Сангийн яаманд тус тус хүргүүлж, олон нийтэд мэдээлсэн.

Аудитын дүнг УИХ-ын ТБХ-ны 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, хуралдааны тэмдэглэлээр Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан чиг үүргийн хүрээнд Төрийн аудитын байгууллагыг тус хуулийн хэрэгжилтэд байнгын хяналт тавих нэгжтэй болох чиглэл өгсний дагуу зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүллээ.



QR кодоор
тайланг
үзнэ үү.

зардлын дээд хэмжээг тогтоох аргачлалыг журамлаж, зардлыг аргачлалын дагуу тооцоолсноор Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50.1 хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 15 дугаар тогтоолын

хэрэгжилт хангагдаж, Монгол Улсын Их Хурлын сонгууль зохион байгуулагдах хуулийн шаардлагын дагуу урьдчилсан нөхцөлийг бүрдүүлж чадсан байна.



УЛСЫН ИХ ХУРЛЫН ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХОО ИЛЭРХИЙЛЖ БҮРТГҮҮЛСЭН УЛС ТӨРИЙН НАМ, ЭВСЭЛ, БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧИЙН СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨРТ ДҮГНЭЛТ ГАРГАХ

Аудитыг гүйцэтгэхэд дагаж мөрдөх аргачлалыг боловсруулах ажлын хэсгийг байгуулан УИХ-ын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт аудит хийж, дүгнэлт гаргах аргачлалыг анх удаа боловсруулан, МУЕА-ын 3 дугаар сарын 20-ны өдрийн А/32 дугаар шийдвэрээр батлан хэрэгжүүллээ.

Аудитад хамрагдахаар хүсэлт ирүүлсэн нам, эвсэл, бие даагчийн тоо, дүгнэлт гаргах хуулийн хугацааг харгалзан МУЕА-ын 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/28, 2020 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн А/34 дугаар тушаалын дагуу нийт 19 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулан, аудитыг гүйцэтгэлээ.

ҮАГ-т дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн нийт 4 эвсэл, 15 намын мөрийн хөтөлбөрт Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3-т заасан мөрийн хөтөлбөрт тусгахыг хориглосон заалт байгаа эсэх, мөрийн хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээ нь мөн хуулийн 38 дугаар зүйлийн 38.5-д заасан Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн эсэх, мөрийн хөтөлбөрт орсон санхүүгийн тодорхой эх

үүсвэр шаардсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд гарах зардлын дүн нь ТТБТХ-д заасан төсвийн тусгай шаардлагад нийцсэн эсэхийг тус тус хянаж 4 эвсэл, 8 намын мөрийн хөтөлбөрийг залруулахаар буцааж, дээрх хуулийн зохицуулалтад нийцүүлэн баталгаажуулж, дүгнэлт гаргалаа.

Мөн аудитаар 121 иргэний мөрийн хөтөлбөрийг Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн, зөрчлийг арилгуулж, мөрийн хөтөлбөрт холбогдох дүгнэлтийг гарган нам, эвсэл, бие даагч болон СЕХ-нд хуулийн хугацаанд хүргүүлж, олон нийтэд мэдээлсэн байна.

УИХ-ын ээлжит сонгуульд оролцохоо илэрхийлж бүртгүүлсэн улс төрийн нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт арга хэмжээг Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүнг ТТБТХ-д заасан төсвийн тусгай шаардлагад нийцүүлэн дүгнэлт гаргалаа.



УЛСЫН ИХ ХУРЛЫН ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН ЖИЛИЙН ӨМНӨХ НЭГ ЖИЛД УЛС ТӨРИЙН НАМУУДАД ИРГЭД, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭЭС ӨГСӨН ХАНДИВЫН ТАЙЛАНГ ХЯНАН БАТАЛГААЖУУЛАХ

Аудитын үе шатны ажлын холбогдох журам, стандартын дагуу гүйцэтгэлийн үе шатанд Улсын дээд шүүхэд бүртгэлтэй 36 намд хандивын тайланг хүлээж авах маягт, холбогдох баримт материалын жагсаалтыг хүргүүлснээс УИХ-ын 2020 оны ээлжит сонгуульд оролцохоор нийт 27 нам хандивын тайлан ирүүлсэн байна.

Аудитыг гүйцэтгэхтэй холбоотой дагаж мөрдөх аргачлалыг боловсруулах ажлын хэсгийг зохион байгуулж, МУЕА-ын 2020 оны А/29 дугаар тушаалаар “Нам, эвслээс ирүүлсэн хандивын тайланг, хянан баталгаажуулж, дүгнэлт гаргах заавар”, “Хандивын тайлангийн дүгнэлтийн загвар”, “Нам, эвсэлд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлангийн маягт”-ыг батлан хэрэгжүүллээ.

Иргэн, хуулийн этгээдээс хандив аваагүй тухай тайлагнасан 19, хандив хүлээн авсан

тухай тайлагнасан 8 намын тайланг хянан баталгаажуулж, холбогдох дүгнэлтийг 2020 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн дотор СЕХ-нд хүргүүлэн олон нийтэд мэдээлэв.

Хандивын тайланг хянан баталгаажуулах явцад хандивыг бэлнээр авах, тогтоосон хязгаараас илүү, тодорхой нэр хаяггүй этгээдээс төвлөрүүлсэн байх, хандив авснаар тайлагнасан боловч баримтаар нотлогдохгүй байсан алдаа зөрчлийг тус тус илрүүлж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлснээр цаашид намууд УИХ-ын сонгуулийн тухай хууль тогтоомжид нийцүүлэн хандив авч, хандивын тайланг үнэн зөв, бодитой гаргаж тайлагнахад чухал үр нөлөө үзүүлэх аудит боллоо.



ГАЗРЫН ТОСНЫ САЛБАРТ БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭГЭЭР ХАЙГУУЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ГЭРЭЭЛЭГЧДИЙН 2017-2018 ОНЫ НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ӨРТӨГ НӨХӨХ ЗАРДЛЫГ БАТАЛГААЖУУЛАХ


Тайлант хугацаанд тайлагналын үе шатны ажлыг холбогдох журам, стандартын дагуу гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 4 дүгээр сарын 08-ны өдөр МУЕА-ын 2020 оны А/36 дугаар тушаалаар эцэслэн баталгаажуулж УИХ болон холбогдох байгууллагуудад хүргүүллээ.

Аудитад АМГТГ-аар батлуулсан төлөвлөгөө, төсвийн дагуу хайгуулын үйл ажиллагаа явуулсан 8 гэрээлэгчийн 9 хайгуулын талбайн хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх зардлыг хамруулж, 7 гэрээлэгчийн 8 талбайн Өртөг нөхөх зардлын тайланд зарим зардлыг Газрын тосны тухай хууль болон бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу үнэн зөв бүртгэж, тайлагнаагүй байсан тул өртөг нөхөгдөх зардлаас нийт 1.8 сая ам.долларын зардлыг хасаж баталгаажуулсан.

“Сентрал азиан Петролеум Корпорэйшн лимитэд” компанийн гэрээт Богд-IV болон Онги-V, “Петроматад инвест лимитэд” компанийн гэрээт “Матад-XX” хайгуулын талбайн өртөг нэмэгдэх зардалд тайлагнасан нийт 1.2 сая ам.долларын гүйлгээг гадаадын банкаар

дамжуулан гүйцэтгэсэн нь Зөрчлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.13.9.2-т заасныг зөрчсөн байж болзошгүй тул Мэргэжлийн хяналтын байгууллагад шалгуулахаар шилжүүлэв.

Газрын тосны тухай хууль болон бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу үнэн зөв бүртгэж, тайлагнаагүй зардлыг хасаж баталгаажуулснаар хайгуулын талбайд олборлолт хийгдэх тохиолдолд Монгол Улсын Засгийн газарт ногдох бүтээгдэхүүний хэмжээ нэмэгдэх, цаашид хайгуулын компаниуд хөрөнгө оруулалт, өртөг нөхөх зардлын тайланг бүтээгдэхүүн хуваах гэрээнд нийцүүлэн тайлагнах, АМГТГ-аас тавих хяналтын чиг үүргээ бүрэн хэрэгжүүлснээр үйл ажиллагаагаа сайжруулж ажиллах үр нөлөө бий болно.





ГАЗРЫН ТОСНЫ САЛБАРТ БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭГЭЭР ОЛБОРЛОЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН “ДОНШЕН ГАЗРЫН ТОС МОНГОЛ” ХХК-ИЙН 2015-2018 ОНЫ НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ӨРТӨГ НӨХСӨН БОЛОН НӨХӨХ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ, ГАЗРЫН ТОСНЫ ЭКСПОРТ, БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН ТООЦОО, ХУВААРИЛАЛТ

Тайлангийн төсөлд санал авах болон албан шаардлагын төслийг холбогдох албан тушаалтанд танилцуулж, албажуулахаар АМГТГ, “Доншен газрын тос Монгол” ХХК-нд 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 01/3190 дугаар албан бичгээр хүргүүлээд байна.

Шалгагдагч байгууллагын шийдвэр гаргах түвшний болон холбогдох мэргэжилтнүүд тодорхой хугацаагаар “Ковид-19” цар тахлын улмаас улсын хил хаагдсантай холбоотойгоор БНХАУ-аас ирэх боломжгүйгээс аудитын зарим горим, сорилыг хэрэгжүүлээгүй хүлээгдсэн тул УИХ-ын ТБХ-ны тогтоолоор аудитын тайлагнах хугацааг 2020 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийг хүртэл сунгасан байна.

Тус аудитаар “Доншен газрын тос (Монгол)” ХХК-ийн “БХГ-97” талбайн 2015-2018 оны хөрөнгө оруулалт, зардал, өртөг нөхсөн болон өртөг нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо хуваарилалтыг Газрын тосны тухай хуульд заасны дагуу хянаж нэгтгэх чиг үүрэг бүхий Газрын тосны газар /хуучин нэрээр/ хуульд заасан чиг үүргээ зохих ёсоор хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгуулж, улсын төсөвт 1.9 сая ам.долларыг төвлөрүүлэх албан шаардлагын төсөлд санал авах шатанд байгаа бөгөөд энэхүү зөрчил баталгаажсанаар улсын төсөвт төвлөрүүлэх орлого бүрэн төвлөрөх боломжтой байна.

ДАРАА ОНД ШИЛЖИЖ БУЙ НИЙЦЛИЙН АУДИТ

“Ковид-19” цар тахлын хөл хорионы нөхцөл байдлаас шалтгаалан зарим аймагт “0” зогсолтын горимд шилжсэнээр тайлан нэгтгэх, үе шатны хяналтад шилжүүлэх хугацаа хойшлоход нөлөөлсөн бөгөөд тайлагналын үе шатны ажил үргэлжилж байгаа дараах аудит байна.



Иргэн, хуулийн этгээдэд газар олголтын байдал, газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах шийдвэр, үйл ажиллагаа нь Газрын тухай хуульд нийцсэн эсэх




Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт



Ойн тухай хуулийн хэрэгжилтийн үр дүн /Булган аймаг дахь ТАГ/

Мэргэжлийн хяналтын газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч хууль бусаар мод бэлтгэхтэй тэмцэж байгаа боловч үр дүн хангалтгүй, жил бүр орон нутгийн хөрөнгөөр хийсэн ойжуулалтын ажлын гүйцэтгэлд тавих хяналт сул зэрэг алдаа зөрчил илэрснийг залруулах, үйл ажиллагаагаа сайжруулж ажиллах зөвлөмж өгч хэрэгжилтийг тооцон ажилласан байна.

- Аймаг, сумдын ИТХ, Засаг дарга, БОАЖГ нь хуульд зааснаар аймаг, сумын төвшинд ойн менежментийн төлөвлөгөөг үйл ажиллагаа явуулж буй ойн нөхөрлөл, ААНБ-ын “Ойн менежментийн төлөвлөгөө”-г батлаагүй, 2019 оны ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх аймгийн галын төлөвлөгөөг боловсруулаагүй, ойн нөхөн сэргээлтийн ажлын үр дүнг тооцоогүй,
- Хэрэглээний мод, түлээ бэлтгэх үйл ажиллагааны дээд хэмжээг тогтоосон аймгийн ИТХ-ын тогтоолын хэрэгжилт, мод бэлтгэх эрхийн бичиг, хууль тогтоомжоор төвлөрүүлэх төлбөр, хураамжийн орлогын гүйцэтгэлд тавих БОАЖГ, сумдын ЗДТГ-ын хяналт сул,
- Ойн нөөц ашигласны орлогын төлөвлөгөө давж биелж байгаа нь үндэслэл муутай буюу ИТХ-аар баталсан модны дээд хязгаарыг баримталдаггүй, мод бэлтгэх хязгаараас хэтрүүлэн зөвшөөрөл олгосон,
- Сумдын төвшинд ойн нөөц ашигласны төлбөрийн орлогоос ой нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг төлөвлөөгүй байсан байна.




QR кодоор
тайланг
үзнэ үү.



Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилт /Дорноговь аймаг дахь ТАГ/

Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг 4-6 удаа сунгаж хуулийн заалтыг зөрчсөн, хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн дийлэнх нь байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулаагүй, хуульд заасны дагуу тухайн жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг байршуулаагүй, холбогдох мэргэжилтэн, байцаагч нар ажлын байранд тогтвор суурьшилтай ажиллаагүй, чиг үүргээ хангалтгүй биелүүлсэн, хариуцлага сул байдлаас шалтгаалж орон нутгийн төсөвт орох орлого бүрэн төвлөрөөгүй, компаниуд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хуулбар хувь, төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг аймаг, сумын Засаг даргад ирүүлээгүй, хамтын ажиллагааны хороог байгуулж ажиллаагүй, гэрээг дүгнэж үр дүнг тооцоогүй, МХГ-ын хяналт шалгалтаар илэрсэн зөрчил арилаагүй байна.




QR кодоор
тайланг
үзнэ үү.



Аймгийн ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж, шийдвэрийн үндэслэл, түүний хэрэгжилт /Говьсүмбэр аймаг дахь ТАГ/

Аудитад 2017-2019 он, 2020 оны эхний хагас жилд батлагдаж хэрэгжсэн аймгийн ИТХ-ын болон Тэргүүлэгчдийн тогтоол, Засаг даргын захирамж зэрэг шийдвэрүүдийг хамруулж, аудитын дүнд үндэслэн “Аймгийн ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамжийн төлөвлөлт, боловсруулалтад тавих хяналт хангалтгүйн улмаас илт хууль бус гэж үзэх үндэслэлтэй захиргааны актууд батлагдсан байна” гэсэн дүгнэлтэд үндэслэн аймгийн ИТХ, Засаг даргад 8 зөвлөмж хүргүүлсэн байна.




QR кодоор
тайланг
үзнэ үү.



Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн хэрэгжилт /Төв аймаг дахь ТАГ/

Аудитад хамрагдагч байгууллага, нэгжээс ирүүлсэн тайлан, судалгаа, холбогдох баримт материалыг хөтөлбөрийн хэрэгжилттэй тулган баталгаажуулахад хөтөлбөрийн хэрэгжилтийг 91 хувьтай буюу “Үр дүнтэй” хэрэгжсэн гэж үнэлсэн нь бодит байдалтай нийцэхгүй, аймгийн хэмжээнд мал хулгайлах гэмт хэргийн гаралт буураагүй, хууль хяналтын байгууллагын илрүүлэлт сул, шүүхээс энэ төрлийн гэмт хэрэгт ял шийтгүүлсэн иргэд болон хохирлын тоо нэмэгдсэн байна.

Сумдын хууль эрх зүйн мэргэжилтнүүдийн тогтвор суурьшилгүй байдал, ажлын баримт материалыг бүрэн хүлээлцээгүй, архивын нэгж үүсгээгүй нь бодитой дүгнэлт гаргах боломжийг хязгаарласан, холбогдох баримт материалыг шаардсан хугацаанд аудитад бүрэн хамруулаагүй тул холбогдох талуудад зөрчил арилгуулах зөвлөмж өгч ажиллажээ.



Хүнс, хөдөө аж ахуйн газрын төсвийн зарцуулалт, хууль тогтоомжийн хэрэгжилт /Сүхбаатар аймаг дахь ТАГ/

Орон нутагт бэлчээрийн усан хангамж дутагдалтай, малын үүлдэр угсааг сайжруулах, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэхээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, бодлогын хэрэгжилт хангалтгүй, ХАА-н салбарт мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай, төсвийн хөрөнгөөр хийгдсэн зарим ажлууд үр ашиггүй болсон, хөрөнгө дутагдаж, хадгалалт, хамгаалалтад эрсдэл учирсан, салбарын үйл ажиллагаа орон нутгийн иргэдэд хүртээмжтэй, үр дүнтэй хүрч чадахгүй байна гэж дүгнэжээ.


Аудитаар 126.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, зөрчил дутагдлыг арилгах 252.7 сая төгрөгийн албан шаардлага өгч, хөтөлбөрийн үр нөлөөг дээшлүүлэх, хэрэгжилтийг хангах, удирдлага зохион байгуулалт, дотоод хяналтыг сайжруулах, бодлогын төлөвлөлтийг үр дүнтэй хийх, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх зэрэг 9 зөвлөмжийг хүргүүлсэн байна.



Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр хураамжийн төлөвлөлт, бүрдүүлэлтийн үр дүн /Ховд аймаг дахь ТАГ/

Аймгийн хэмжээнд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 9 ААН байгаагаас үйл ажиллагаа явуулж байгаа ч тусгай зөвшөөрөл эзэмшигч 3 ААН хуульд заасан хугацаанд төлбөрөө төлөөгүй, түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах, хайгуул хийх тусгай зөвшөөрөл олгох талбайн байршил хэмжээг газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгахгүйгээр олгосон, мөн Дөргөн суманд түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах нөөц боломж байхгүй байхад орлогын төлөвлөгөө батлуулсан зэрэг алдаа зөрчил илэрсэн байна.

Аудитын дүнд үндэслэн “Зарим тусгай зөвшөөрлийг газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгахгүйгээр олгосон, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашиглах, төлбөр төлөх эрх зүйн зохицуулалттай боловч хуулийн хэрэгжилт хангалтгүй, түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөрийн гүйцэтгэлийн хяналт хийгдээгүй тул үр нөлөөг тооцох боломжгүй байна” гэсэн дүгнэлт гаргажээ.



Хүснэгт 2 АНТАГ-уудын гүйцэтгэсэн Нийцлийн аудитын сэдэв, ангиллаар

Д.д	Сэдвийн ангилал	Аймаг, нийслэлийн ИТХ-ын хүсэлтээр	Өөрийн санаачилгаар	Нийт
1	Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын өмчийн ашиглалттай холбоотой	1	7	8
2	УИХ-аас баталсан хууль тогтоомж, ЗГ, ИТХ-аас баталсан төсөл, хөтөлбөр, бусад чиглэл	3	7	10
3	Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын үйл ажиллагаа, шийдвэрийн хэрэгжилттэй холбоотой	2	2	4
4	Уул уурхай, байгалийн баялаг, нөхөн сэргээлттэй холбоотой	1	2	3
Нийт		7	18	25

Төрлөк өндөрлөк



З

УДИРДЛАГА, ЗОХИОН
БАЙГУУЛАЛТ,
АУДИТЫГ ДЭМЖИХ
ҮЙЛЧИЛГЭЭ



УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны 01 дүгээр тогтоолыг үндэслэн МУЕА-ын 2020 оны "Үндэсний аудитын газрын зохион байгуулалтын бүтэц, бүтцийн нэгжүүдийн үндсэн үйл ажиллагааны чиг үүрэг, орон тоо, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай" А/02 дугаар тушаалыг батлан хэрэгжүүлж ажиллалаа.

УИХ-ын ТБХ-ны 2020 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар ТАБ-ын 2019 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцсэн болон байгууллагын үйл ажиллагаанд хийсэн системчилсэн үнэлгээний дүн, МУЕА-ын 2020 онд шинэчлэн баталсан А/20 дугаар тушаалаар "Төрийн аудитын байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"-ын дагуу Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 үндсэн чиглэлээр 114 багц арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусган хэрэгжилтийг хангаж ажиллав.



УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2020 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 6 дугаар тогтоолоор Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааг дэмжин орон тоог өөрчлөн баталсны дагуу зохион байгуулалт, бүтэц, орон тоо, чиг үүргийн шинжилгээг гүйцэтгэж, шинэчлэлийг 2021 оноос зохион байгуулж мөрдүүлэхээр зорилт дэвшүүлэн үе шатны ажлыг гүйцэтгэлээ.

Зохион байгуулалтын өнөөгийн тогтолцоо, үйл ажиллагааны төлөв байдлыг хянан үзэж, зохион байгуулалт, бүтцийн шинэчлэлийг гүйцэтгэлийн хэмжүүрийн тогтолцоо, түүний үр дүнгийн байдал, шинээр үүсэн бий болох нөхцөл байдалтай уялдуулан нөхвөл зохих буюу хэтийн хугацааны хөгжлийн өөрчлөлттэй уялдуулах, тогтвортой үйл ажиллагааг хангах өөрчлөлтийн удирдлагыг цаг алдалгүй зайлшгүй хэрэгжүүлэх бодлогыг баримтлалаа.

УИХ-ын 2019 оны 56 дугаар тогтоолоор Төрийн аудитын байгууллагын албан хаагчдын албан тушаалын цалинг шинэчлэн баталж, түүний дагуу 2020 оны эхнээс хэрэгжилтийг ханган УАГ-ын болон аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын албан хаагчдын албан тушаалын цалинг шинэчлэн мөрдүүлэв.

ТАБ-ын Удирдах ажилтны зөвлөгөөний хөтөлбөр, зохион байгуулалтын төлөвлөгөөг Улсын онцгой комиссын хянан баталгаажуулснаар 2020 оны 5 дугаар сард амжилттай зохион байгуулж 2019 оны дүн, 2020 оны болон төрийн аудитын байгууллагын цаашдын хөгжлийн бодлого, стратегийн зорилтын асуудлыг хэлэлцүүлээ.

Удирдах ажилтны зөвлөгөөнөөр ТАБ-ын 2020 онд гүйцэтгэх аудитын сэдэв, УИХ-ын болон орон нутгийн сонгуулийн хууль тогтоомжтой холбогдуулан гүйцэтгэх аудитын дүгнэлт гаргах чиг үүргийг хэрэгжүүлэхэд арга зүйн зөвлөмж, чиглэл өгөх,



хуулийн нэрийн өмнөөс төрийн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэх асуудлыг байнгын анхааралд байлгахыг харилцан ойлголцож, үйл ажиллагааны үндсэн чиглэлээ тодорхойлов.

ТАБ-аас 2020 оны онцгой нөхцөл байдлын үед зохион байгуулсан Удирдах ажилтны зөвлөгөөний шийдвэрийн хэрэгжилтийг ханган үйл ажиллагааны ололтоо бататган аудитын дүн, үр нөлөөг олон нийтэд төрийн аудитын стандарт, холбогдох зөвлөмж бодлого, арга зүйн дагуу хэрэгжүүлж, Төв, Дархан-Уул, Сэлэнгэ аймаг дахь ТАГ-ууд шинэлэг санал, санаачилгыг гаргаж, зохих үр дүнд хүрч ажилласан байна.

ҮАГ-ын зохион байгуулалтын бүтэц, бүтцийн нэгжүүдийн үндсэн үйл ажиллагааны чиг үүрэг, орон тоо, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн баталсантай холбогдуулан 2020 оны А/25 дугаар тушаалаар АНТАГ, А/11 дүгээр тушаалаар ҮАГ-ын ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтыг

тус тус шинэчлэн баталж мөрдүүлээ.

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 вирусын халдвар тархаж, Монгол улс ч иргэдийнхээ аюулгүй байдал онцгой анхаарч, урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг авч өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллаж байгаа үед УОК-ын үйл ажиллагааг дэмжих зорилгоор ТАБ-ын нийт албан хаагчид мөнгөн хандив цуглуулах аяныг өрнүүлж хүлээлгэн өглөө.

Нийт 76 орны АДБ-уудын мэдээллээр 2020 онд бүрэн болон хэсэгчилсэн байдлаар зайнаас ажиллах шинэ горимд шилжин үүсээд байгаа нөхцөл байдалтай уялдуулан, орон зайн хамааралгүйгээр үр нөлөөтэй ажиллах, ажилтнуудын цахим орчинд ажиллах үр чадварыг хөгжүүлэх шаардлагын дагуу удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

2020 онд эхлүүлсэн шинэчлэлийн арга хэмжээ:

Цар тахлын үед буюу гамшгийн болон хямралын үед гүйцэтгэх аудитын сэдэв, чиглэлийг тодорхойлох, хэрэгжүүлэх удирдамж гаргах, аудитын үр дүн, тайлагналыг олон нийтэд ил тод нээлттэй болгох бодлого, арга зүйн заавар, зөвлөмжийг боловсруулах ажлыг үе шаттайгаар эхлүүлээд байна.

УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2020 оны 05 дугаар тогтоолоор "Үндэсний аудитын газрын 2021 онд гүйцэтгэх аудитын сэдэв"-ийг баталсны дагуу хууль тогтоомж, бодлогоор гүйцэтгэх аудитын сэдвийн нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж, урьдчилсан судалгааны ажлыг эхлүүлэв.

МУЕА-ын 2019 оны А/76-1 дүгээр тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын 2019-2024 оны стратеги төлөвлөгөө"-ний 2019, 2020 оны хэрэгжилтийг үнэлж, Монгол улсын "Алсын хараа-2050" урт хугацааны хөгжлийн бодлогыг дэмжсэн буюу уг баримт бичигтээ шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулж, шинэчлэн сайжруулах ажлыг эхлүүлээ.

ТАБ-ын зохион байгуулалтын бүтцийн шинэчлэл, нэгжүүдийн үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэлийг шинэчлэх зохион байгуулалт, өөрчлөлтийн удирдлагыг хэрэгжүүлэх ажлыг эхлүүлэв.

ЭРХ ЗҮЙН ДЭМЖИХ ҮЙЛЧИЛГЭЭ

Эрх зүйн дэмжих үйлчилгээний хүрээнд ТАБ-ын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж болон эрх зүйн баримт бичгийн хэрэгжилт, тулгамдсан асуудлын талаар судалгаа хийн тэдгээрийг боловсронгуй болгож, шинэчлэн сайжруулах ажлыг эн тэргүүнд гол чиглэлээ болгосноор аудитыг дэмжсэн эрх зүйн шинэчлэлд ахиц гарлаа.

Тайлант онд хуулийн шинэчлэл, аудитын эрх зүйн орчныг сайжруулах стратегийн зорилтын хүрээнд Төрийн аудитын тухай хууль /шинэчилсэн найруулга/ батлагдаж, мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан шинээр болон шинэчлэн батлах дүрэм журам, баримт бичгийг боловсруулах 15 дэд ажлыг гүйцэтгэхээр баталж үе шатны ажлыг эхлүүлсэн.

ТАБ-ын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж болон эрх зүйн баримт бичгийн хэрэгжилт, тулгамдсан асуудлын талаар судалгаа хийх боловсронгуй болгож, шинэчлэх зорилтын хүрээнд байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа дүрэм, журмуудыг хуулийн шинэчлэлд нийцүүлэх, цаг үеийн шаардлагатай эрх зүйн актыг цаг алдалгүй боловсруулан баталж мөрдүүлэх, төлбөрийн актын хэрэгжилтэд төлөв байдлын судалгааг хийж ажилласны дүнд тайлант онд нийт 23 дүрэм



заавар, аргачлалыг шинэчлэн боловсруулж баталснаас 12 нь аудитын үйл ажиллагаатай холбоотой байна.

Төрийн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардлагатай дүрэм журам, заавар аргачлалын шинэчлэл нь тасралтгүй үргэлжлэх, байнгын дэмжих эрх зүйн үйлчилгээ буюу цаашид төрийн санхүү, төсвийн хяналтыг хэрэгжүүлэх аудитын үйл ажиллагаанд сайжралт гаргахуйц ахиц дэвшилд чиглэгдэж байна.

ТАБ-ын ажилтнуудын албан үүргээ гүйцэтгэхэд шаардагдах хууль зүйн зөвлөгөө өгөх, эрх зүйн актыг сурталчлах, мэдээлэл өгөх ажлын хүрээнд төрөлжсөн болон АНТАГ-уудын захиргааны шийдвэр гаргах үйл ажиллагаанд эрх зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлж Говь-Алтай, Увс, Говьсүмбэр, Булган, Завхан, Хэнтий, Дундговь, Дорноговь, Орхон, Дорнод аймаг дахь ТАГ-ын тогтоосон төлбөрийн акт хууль, эрх зүйд нийцсэн байдалд судалгаа хийж, үр дүнг тайлагнасан байна.

ҮАГ-ын Удирдлагын зөвлөлийн хуралдааныг 6 удаа зохион байгуулж 18 асуудал, Ёс зүйн зөвлөлийн 5 удаагийн хурлыг журмын дагуу зохион байгуулж, зохих шийдвэрийг гарган ажиллажээ.



АУДИТЫН ХӨГЖҮҮЛЭЛТ



Төрийн аудитын шинэчлэлийн бодлого нь "Аудитын хөгжүүлэлт"-д чиглэгдэж, олон улсын сайн туршлага, стандарт, жишигт нийцсэн чанартай аудитыг гүйцэтгэж, эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг бий болгоход оршиж байна.



ИНТОСАИ-аас гаргасан "Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт"-ыг УАГ болон СХЗГ-тай хамтран Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн шаардлагад

нийцүүлэн Банк, санхүү, даатгалын стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцүүлснээр Монгол Улсын "Төрийн аудит"-ын стандарт болгон баталгаажуулж уг /MNS 6817:2020/ стандартыг 2020 оны 1 дүгээр сарын 15-ны өдрөөс мөрдөж эхэллээ.

АДБОУС-ыг Монгол Улсын "Төрийн аудит"-ын стандартаар баталгаажуулсан нь төрийн аудитын байгууллагын бодлого, арга зүйг боловсронгуй болгох, аудитын чанар, үр нөлөөг дээшлүүлэх, хэрэглэгчдийн итгэлийг бэхжүүлэх, үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, үүрэг хариуцлагыг тодорхой болгоход чухал алхам болж төлөвшүүлэх, дагалдан гарах заавар аргачлалыг боловсруулах ажлыг гүйцэтгэж байна.

Төрийн аудитын байгууллагаас 2019-2020 онд санхүүгийн тайлангийн аудит хийх ерөнхий чиглэлийг тодорхойлж, аргачилсан зөвлөмж, нэгдсэн судалгааны маягт бэлтгэж, Санхүүгийн аудитын газар болон АНТАГ-т хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж ирэв.

Санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэх ерөнхий чиглэлийн дагуу аудитын явцад учирч болох 28 эрсдэл, горимыг холбогдох хууль эрх зүйн орчин, бусад шалгуур үзүүлэлтүүдэд хамааруулан боловсруулж, СТАУС програмын эрсдэлийн санд цахим хэлбэрээр оруулснаар санхүүгийн тайлангийн аудитын үр нөлөөг дээшлүүлэх боломж бүрдэж байна.

ЦАХИМ СУРГАЛТ, ХӨГЖЛИЙН АРГА ХЭМЖЭЭ


Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн А/30 дугаар тушаалаар байгууллагын 2020 оны сургалтын чиглэл, ерөнхий болон дэлгэрэнгүй төлөвлөгөө, хөтөлбөрийг баталж хэрэгжүүлж байна.

ТАБ-ын хувьд 2020 он цахим сургалт, хөгжлийн нэгдсэн системийг боловсруулан хөгжүүлэлт хийн бэлтгэл ажлыг хангаснаар сургалтын тогтолцоог шинэ шатанд гаргах ажлын эхлэл болов. ТАБ-ын 2019-2024 оны стратеги төлөвлөгөө, 2018-2022 оны сургалт, хөгжлийн стратеги төлөвлөгөөнд үндэслэсэн 2020 оноос сургалтын үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг системтэйгээр төлөвлөн хэрэгжүүлсэн.

Цахим сургалт, хөгжлийн арга хэмжээний хүрээнд төлөвлөж хэрэгжүүлсэн арга хэмжээ нь аудитад мэдээллийн дэвшилтэт технологи, програм хангамжийг өргөн ашиглах, аудиторуудын чадавх, мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэхэд чиглэгдэж байна.

“Ковид-19” цар тахал гарсантай холбоотой 2020 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд тусгасан танхимын сургалт хэрэгжих боломжгүй болсон ч цахимаар зохион байгуулахаар шийдвэрлэн сургалтын төлөвлөгөөг шинэчлэн хэрэгжүүлж байна.


ТАБ-ын цахим сургалтын үе шатны үндсэн чиглэл:



ТАБ-ын цахим сургалтыг 3 үе шаттай хөгжүүлэх зураглал гаргаснаар 2020 оныг цахим сургалтыг нэвтрүүлэх үе шат гэж тодорхойлсон бөгөөд амжилттай нэвтрүүлэхийн тулд үйл ажиллагааг нарийвчлан төлөвлөж хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд бусад төрийн байгууллагуудад жишиг болох

цахим сургалтын системийг хөгжүүлж, цогц мэдлэгийг системтэй олгох цахим хичээлийг нэвтрүүлснээр сургалтад нийт албан хаагчид хамрагдаж, 94 хувийн амжилттай дүгнэгдсэн байна.

Цахим сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо



Цахим сургалтын хүрээнд 2020 онд гүйцэтгэсэн ажил



ГАДААД СУРГАЛТ

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас гадаад улсын АДБ-тай хамтарсан танхимын сургалт хэрэгжих боломжгүй болсон ч цахим сургалт, хөгжлийн арга хэмжээний

хүрээнд олон улсын хамтарсан сургалтад идэвхтэй хамрагдаж, хөгжлийн шаардлагад нийцсэн хүний нөөцийг бүрдүүлэх бодлогын хэрэгжилтэд ахиц гарлаа.

- ИНТОСАИ-ын Аи Ди Аи, АСОСАИ-аас сургалт цахим хэлбэрт шилжиж "КОВИД-19 цаг үеийн Стратегийн удирдлага", "КОВИД-19 цаг үеийн Эрсдэлийн удирдлага", "КОВИД-19 цаг үеийн нөөцийг ашиглах ба тэргүүлэх чиглэлийг тодорхойлох", "КОВИД-19 цаг үеийн Хяналт-шинжилгээ, үнэлгээ ба стратегийн төлөвлөгөө" боловсруулах цахим сургалтад амжилттай хамрагдлаа.
- ҮАГ болон БНХАУ Аудитын дээд байгууллагын хооронд байгуулсан санамж бичгийн хэрэгжилтийн хүрээнд БНХАУ-ын Үндэсний аудитын газраас 2020 оны 09 дүгээр сарын 22-23-ны өдрүүдэд Монгол Улсын Үндэсний аудитын газрын албан хаагчдад зориулсан чадавхыг бэхжүүлэх цахим сургалтыг зохион байгуулж 68 албан хаагч оролцов.
- Румын болон БНЭУ-ын ТАБ хамтран зохион байгуулсан "Мэдээллийн технологийн аудит" хийх туршлага солилцох цахим сургалтад хамрагдаж, Малайз, Канад, Энэтхэг, Афганистан, Япон улсын төрийн аудитын туршлагаас суралцсан байна.
- Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд ИНТОСАИ-н Аи Ди Аи-аас зохион байгуулж буй "Тогтвортой хөгжлийн зорилтод аудит хийх" хөтөлбөрт хамрагдаж байна.

СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ, ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

Бүтэц, зохион байгуулалтын шинэчлэлтийн хүрээнд хүний нөөцийн бодлогод тулгуурласан сургалт, хөгжлийн стратегийг хэрэгжүүлэх замаар аудиторчуудын ур чадвар, чадавхыг сайжруулахаас гадна хөгжлийн тогтсон горим, тогтолцоо бий болгон хөгжүүлж, төлөвшүүлэх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд судалгааны ажлыг бүтцийн бүх нэгжүүд хийж гүйцэтгэж байхаар зохион байгуулалтын удирдлагыг хэрэгжүүлж байна.



ИНТОСАИ-н Хөгжлийн санаачилгаас зохион байгуулж буй “Тогтвортой хөгжлийн зорилтод аудит хийх” хөтөлбөр

ИНТОСАИ-аас гаргасан зөвлөмж, зааврын дагуу хамтран хийх Тогтвортой хөгжлийн зорилтын хэрэгжилтэд хийх аудит /Эрүүл мэндийн салбарын бодлого, тогтолцоонд тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилт, үр дүн/-д оролцож аудитын багийн мэдүүлгийг олон улсын байгууллагад илгээн чиглүүлэх сургалт, хөтөлбөрийн хэлэлцүүлэгт хамрагдаж байна. Хөтөлбөрийн дагуу төлөвлөлт, урьдчилсан судалгааны ажлыг эхлүүлж үндсэн мэдээллийг цуглуулах сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулаад байна.



Аудитын дээд байгууллагын гүйцэтгэлийн хэмжүүрийн тогтолцоонд үнэлгээ хийх чадавхыг бэхжүүлэх хөтөлбөр

ИНТОСАИ-н Хөгжлийн санаачилга, АСОСАИ-тай хамтран Аудитын дээд байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилго бүхий Аудитын дээд байгууллагын “Гүйцэтгэлийн Хэмжүүрийн тогтолцоо”-нд үнэлгээ хийх чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрт хамрагдсаны дагуу Гүйцэтгэлийн хэмжүүрийн тогтолцооны үнэлгээ, аргачлалын дагуу “Үндэсний аудитын газрын гүйцэтгэл”-д үнэлгээ хийв.

Үнэлгээний ажлыг ТАБ-ын Хараат бус байдал ба Хууль эрх зүйн орчин, Дотоод засаглал ба Ёс зүй, Аудитын чанар ба Тайлагнал, Санхүүгийн удирдлага, Хөрөнгө, Дэмжих үйлчилгээ, Хүний нөөц ба Сургалт болон Харилцаа холбоо ба Харилцагч талуудын удирдлага гэсэн зургаан хүрээгээр хэмжин үнэлж “Төрийн аудитын байгууллагын гүйцэтгэлийн тайлан”-г боловсруулав.



Төрийн аудитын байгууллагын чадавхыг бэхжүүлэх төсөл

АХБ-ны дэмжлэгтэй “ТА 9731-МОН” төслийн хүрээнд аудитад их өгөгдөлд суурилсан дүн шинжилгээний арга зүйг нэвтрүүлэх горим, тогтолцоог дэмжих судалгааны ажлыг гүйцэтгэж эхлэлийн тайланг гаргаж 2021 онд хэрэгжүүлэх ажлаа төлөвлөлөө.



Дэлхийн Банк болон Европын Холбооны итгэлцлийн сангийн санхүүжилттэй “Монгол Улсад Засаглалыг бэхжүүлэх” төсөл

Дэлхийн Банк болон Европын Холбооны итгэлцлийн сангийн санхүүжилттэй “Монгол Улсад Засаглалыг бэхжүүлэх” төслийн хүрээнд ТАБ-ын үйл ажиллагаа, аудитын тайлан, мэдээллийг иргэдэд нээлттэй, ил тод хялбар мэдээлэх гар утасны програм, веб платформ бий болгох ажлыг гүйцэтгэж шаардлагатай мэдээ, мэдээллийг тухай бүр гарган ажиллалаа. Төслийн хүрээнд “Төрийн аудитын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах 2020-2023 оны стратеги”-ийг батлан хэрэгжүүлж эхэллээ.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТ



23
Зөвлөмж



9
Шийдвэрлэсэн гомдол

МУЕА-ын 2020 оны “Үндэсний аудитын газрын үндсэн үйл ажиллагааны чиг үүрэг” батлах тухай А/02 тушаалаар дотоод аудитын албыг шинэчлэн Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрыг шинээр зохион байгуулж ажиллуулав.

“Төрийн аудитын байгууллагын хэмжээнд хэрэгжих хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх түр журам”-ыг шинээр боловсруулан МУЕА-ын 2020 оны А/60 дугаар тушаалаар батлан, тус газарт

хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр 11 чиг үүрэг, дотоод аудитын чиглэлээр 6 чиг үүргийг хариуцуулж, мөн 2020 оны А/61 дүгээр тушаалаар Төрийн аудитын байгууллагын хэмжээнд хэрэгжих “Дотоод аудитын журам”-ыг батлан мөрдүүлэв.

Бүтцийн нэгжүүдийн тайлан, хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөр, баримт бичгийн хэрэгжилтийн тайлагналд тухай бүр нь хяналт-шинжилгээ хийн ТАБ-аас баримтлах бодлого, шийдвэртэй холбоотой асуудлаар дүгнэлт зөвлөмж гаргаж ирсэн бөгөөд нэгдсэн удирдамжаар гүйцэтгэсэн аудитын дүн, тайлангаар хүргүүлсэн санал хэрхэн шийдвэрлэгдсэн болон аудитын зөвлөмжийн хэрэгжилтийн үнэн зөв байдал, аудитын чанар, хугацаанд нөлөөлөх нөлөөллийг арилгаж аудитад мэдээллийн технологийн ашиглалтыг сайжруулах зөвлөмжийг бүтцийн нэгжүүдийн анхааралд толилуулан ажиллав.

ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТ



403
Зөвлөмж

Төрөлжсөн аудитын чанарын хяналтын болон тогтолцооны төвшинд хэрэгжвэл зохих чанарын горимыг хэрэгжүүлсэн эсэхийг дотоод нэгжийн болон хамтын ажиллагаатай хөндлөнгийн аудитын байгууллагын хүрээнд зохион байгуулж ирлээ.

Төрөлжсөн аудитын чиглэлээр чанарын баталгаажуулалт хийх аудитын хэтийн болон

жилийн төлөвлөгөөнд суурилан боловсруулан холбогдох шийдвэр, удирдамжийн дагуу төлөвлөгөөт ажлыг хэрэгжүүлснээс төлөвлөгөөт 57, төлөвлөгөөт бус 25, нийт 82 аудитад чанарын баталгаажуулалт хийж холбогдох асуудлаар 403 зөвлөмжийг холбоотой талуудад хүргүүлэн хэрэгжилтийг тооцон ажилласан байна.

Онцгой нөхцөл байдалтай уялдуулан “Аудитын чанарын баталгаажуулалтын журам”-ын дагуу 6 аймаг дахь ТАГ-ын аудитын төвшинд чанарын баталгаажуулалтыг цахим хэлбэрээр гүйцэтгэлээ.

- Санхүүгийн тайлангийн аудитын чанарын баталгаажуулалт
- Гүйцэтгэлийн аудитын чанарын баталгаажуулалт
- Нийцлийн аудитын чанарын баталгаажуулалт
- Зарим аймаг дахь ТАГ-ын гүйцэтгэсэн аудитын төвшинд хийсэн чанарын баталгаажуулалт
- Гэрээт ажлын аудитын төвшинд хийсэн чанарын баталгаажуулалт

ИЛ ТОД БАЙДАЛ

Хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд үр дүн бүхий аудитыг хийхийн тулд шинжлэх ухааны ололт, орчин үеийн мэдээлэл технологийн арга хэлбэрийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, түүнийг боловсронгуй болгох арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх, цахим мэдээллийн нэгдсэн системийг үйл ажиллагаандаа ашиглах боломжийг бүрдүүлэх, төрийн аудит нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байхаар тодорхойлсны дагуу аудитад шаардлагатай мэдээллийг цуглуулах, дамжуулах, хадгалах, дүн шинжилгээ хийх зорилгоор мэдээллийн нэгдсэн системийн ашиглалт, хөгжүүлэлтийн дунд болон урт хугацааны бодлогыг төлөвлөн хэрэгжүүлж байна.

Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд болон ТАБ-ын бодлого гүйцэтгэж байгаа аудитын үр нөлөөг сайжруулах, олон нийт, нийгмийн анхааралд байгаа асуудлыг аудитын үндсэн болон дэд зорилт, асуудлын шинжилгээнд тусган, ил тод байдлын хүрээнд харилцагч талуудаас нээлттэй санал асуулга авч аудитад ашигласан байна.

- Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн байдал
- Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаа
- Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.6 км авто зам төслийн хэрэгжилт, үр дүн
- Агаар, орчны бохирдол

АУДИТЫН ТАЙЛАН ҮЗЭХ ЗААВАР

Төрийн аудитын байгууллагын албан ёсны цахим хуудас www.audit.mn



QR кодоор
цахим
хуудас руу
зочилно уу.

1. www.audit.mn сайтын баруун дээд өнцөгт байрлах **АУДИТЫН ТАЙЛАН** гэсэн баннер дээр дарж шууд tailan.audit.mn хуудсыг гарган хайлт хэсэгт үзэхийг хүссэн тайлангийн нэрийг бичиж болно.
2. www.audit.mn сайтын баруун дээд өнцөгт байрлах **ИЛ ТОД БАЙДАЛ** цэсийн **АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА** гэсэн хэсгийг сонгож **АУДИТЫН ТАЙЛАН**-гаас хүссэн тайлангаа үзэж, татан авах боломжтой.
3. Санал хүсэлт болон асуух зүйлийг info@audit.gov.mn цахим хаягаар илгээнэ үү.



МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ



Мэдээллийн технологийг нэвтрүүлэх зорилтын хүрээнд аудитын үйл ажиллагааг тухай бүр бүртгэх, аудитыг гүйцэтгэхэд мэдээллээр бүрэн хангагдсан байх нөхцөлийг бүрдүүлж, нэгдсэн удирдлагаар хангах, үйл ажиллагааны үр дүн, статистикийн мэдээллийн боловсруулалтыг сайжруулах, явцыг тухай бүр харах, хянах боломжтой байх, үйл ажиллагааг харилцагч талуудад нээлттэй ил тод болгох зорилгоор цахим мэдээллийн сангийн бүрдүүлэлтэд шинэчлэл хийхээр зорьж, үйл ажиллагаагаа явууллаа.

ТАБ-ын үндсэн үйл ажиллагаа болон удирдлага, зохион байгуулалт, бүтцийн үйл ажиллагааг мэдээлэл бүртгэлийн нэгдсэн системд бүрэн тусгаж, аудитад шаардлагатай мэдээлэл, түүний эх үүсвэрийг тодорхойлж, харилцагч талуудын мэдээллийн системтэй холбогдох мэдээллийн дэд бүтэц, эрсдэлийн удирдлагын модулийг хөгжүүлэх ажлыг эхлүүллээ.

Төрийн аудитыг гүйцэтгэхэд шалгагдагч хуулийн этгээд, хүний хүчин зүйлсээс хамааралгүйгээр оновчтой сонголт хийх боломжийг бий болгож, аудитын үр нөлөө, үйл ажиллагааны үр ашигтай байдлыг дээшлүүлэх, урьдчилсан судалгаа, их өгөгдөлд суурилсан дүн шинжилгээ хийх ухаалаг тайлангийн дэд системийг хөгжүүлэх ажлын бэлтгэлийг хангаад байна.



Тоон гарын үсэг: ТАБ-ын хэмжээнд тоон гарын үсэг нэвтрүүлэхэд шаардлагатай програм хангамж болон тоон гарын үсэг тээгч төхөөрөмжийн судалгааг нарийвчлан хийж холбогдох байгууллагуудтай гэрээ байгуулан худалдан авч тохируулгыг хийсний үндсэн дээр гарын авлага, зааврыг бэлтгэн байгууллагын нийт ажилтнуудад тоон гарын үсэг олгох ажлыг гүйцэтгэв.



Болор дуран програм: Байгууллагын үндсэн үйл ажиллагааны тайлан, албан бичиг, тушаал, шийдвэр зэргийг үг үсгийн алдаагүй байлгах зорилгоор Монгол хэлний үг, үсгийн дүрмийн алдаа шалгагч “Болор дуран” програм хангамжийн лицензийг 3 жилийн хугацаатайгаар сунгах эрх авч ашиглаж байна.



www.audit.mn


Байгууллагын цахим хуудас: Байгууллагын цахим хуудсын загвар, дизайнд зарчмын өөрчлөлт оруулахгүйгээр WordPress CMS-д шинээр бүтээсэн бөгөөд нэмэлт сайжруулалт, өөрчлөлтүүдийг 2020 оны 09 дүгээр сард хийж нийт мэдээ, мэдээллийг дахин оруулж холбогдох шилжүүлэлт, тохируулгыг богино хугацаанд хийж байна.



Цахим архив: Цаасан суурьт архивын баримтаас цахим архив үүсгэх Org AMS програм хангамжийг 2020 оны 05 дугаар сард нэвтрүүлж АНТАГ-ын ажилтнуудад програмд нэвтрэн ажиллах эрх үүсгэж, холбогдох тохируулгыг хийж зохистой горимоор ажиллуулах, архив, бичиг хэргийн ажилтнуудад сургалт хийхээр төлөвлөсөн ажил хойшилсон ч програмыг ашиглах заавар, гарын авлагыг цахим хэлбэрээр боловсруулан нэвтрүүлээд байна.

МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙН ТАСРАЛТГҮЙ АЖИЛЛАГАА, АЮУЛГҮЙ БАЙДАЛ

- ТАБ-ын цахим хуудас (www.audit.mn), Санхүүгийн тайлангийн удирдлагын систем (<https://staus.audit.mn>), байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлийн онлайн програм (<https://unicus.audit.mn>), дотоод удирдлагын Эйбл (<https://able.audit.mn>) системд аюулгүй холболтын SSL сертификатыг суулгаж, шаардлагатай тохируулгыг хийгээд байна.
- Системд ашиглагдаж байгаа нийт суурин болон зөөврийн компьютер, сервер компьютеруудыг хорт кодоос хамгаалах зорилгоор нэгдсэн удирдлагатай Касперский болон Есэт програмуудын албан ёсны лицензийг хүлээн авч суулган холбогдох заавар зөвлөгөөг бэлтгүүлэн ажиллаж, нэгдсэн удирдлагын серверийн шинэчлэлтийг тухай бүрт хийн шаардлагатай програмын суулгацыг бэлтгэн, мэдээллийн технологийн ажилтнуудын мэргэшлийн суурь мэдлэг олгож ирээ.
- “Дижитал аудит 2025” төслийн хөгжүүлж буй <http://open.audit.mn> Аудитын тайлангийн нэгдсэн системийг ажиллуулах сервер компьютерыг шинээр тохируулж, шаардлагатай сүлжээний, домэйн хаягийн болон хэрэглэгчийн тохируулгыг хийж гүйцэтгэлээ.
- Сургалт, хөгжлийн цахим <http://surgalt.audit.mn> системийн сүлжээний орчин, шаардлагатай тохируулгыг хийн хянаж байна.



ТАБ-ын нэгдсэн VPN сүлжээ, интернэт гарцын хэвийн, тасралтгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангах, гадны халдлага, хорт код илрүүлэх, таслан зогсоох зорилгоор аймаг, нийслэл дэх салбар байгууллагуудад сүлжээний хамгаалалтын Fortinet төхөөрөмжийг худалдан авч, тохируулах, турших, суурилуулах ажлыг гүйцэтгэв. Тоног төхөөрөмжийн шинэчлэлт, тохируулгын өөрчлөлт хийгдсэнээр салбар нэгжүүд RPTP холболтын протокол ашиглаж байсныг IPsec болгон өөрчилж, аюулгүйн ажиллагааны

төвшин сайжирсан. ТАБ-ын гадаад болон дотоод сүлжээний халдлага, аюул, эмзэг байдал, холбогдсон хэрэглэгчийн лог бүртгэл зэрэг олон төрлийн мэдээ, тайлан гарган авах боломжтой болголоо.

ТАБ-ын Мэдээллийн технологийн бодлого “2020-2025” баримт бичгийн төслийг боловсруулан бэлэн болгож, нэгдсэн мэдээллийн системийг хөгжүүлж, нэвтрүүлэх ажлыг III үе шат бүхий V зорилтын хүрээнд хийж гүйцэтгэхээр уг баримт бичигт тусгаад байна.

ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА



Дэлхийн улс, орнууд төдийгүй дотоодод үүссэн нөхцөл байдлын улмаас ҮАГ-аас гадаад харилцаа, хамтын ажиллагааны зорилтын хүрээнд ажил хэрэг болгох зарим арга хэмжээ хэрэгжихгүйд хүрсэн ч ИНТОСАИ болон хамтын ажиллагаатай АДБ-уудын сайн туршлага, харилцаа хамтын ажиллагааны уламжлалыг орхигдуулахгүйгээр

тодорхой ахиц дэвшлийг хадгалан ажилласан болно.

ОХУ-ын Тооцооны танхимтай газрын тос боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаа, түүнд ТАБ-аас хийх аудитын асуудлаар сайн туршлага, мэдээлэл солилцсоноос гадна Тооцооны танхимын даргын албан захидлыг манай улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд И.К.Азизов МУЕА-т гардуулан өгч, цаашдын хамтын ажиллагааны талаар нэгдсэн ойлголцолд хүрсэн байна.

АНУ-аас манай улсад суугаа Элчин сайдын яамны Нэгдүгээр нарийн бичгийн дарга бөгөөд Эдийн засаг, худалдааны албаны дарга Бэнжамин А.Ле Ройтой уулзалт зохион байгуулагдаж Монгол Улсын ТАБ-ын үйл ажиллагаа болон манай улсын улсын банк, санхүүгийн салбарын өнөөгийн байдлын талаар хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр санал солилцов.



ОХУ, БНХАУ, БНСУ, БНСВУ, БНЭУ, БНТУ болон Гүрж, Филиппин, Канад зэрэг улсын АДБ-уудын дээд удирдлагатай албан харилцааны хүрээнд мэдээлэл, санал солилцож ажилласан байна.



НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн болон Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын төлөөлөгч нартай ҮАГ-ын холбогдох төвшний удирдлагууд уулзалт зохион байгуулж, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцлоо.



Япон улсын “Жайка” байгууллага, ЕАБХАБ, Азийн бүтээмжийн байгууллагатай хамтын ажиллагааг идэвхжүүлэн ажиллаж байна.



БНХАУ-ын Ерөнхий аудитор Хатагтай Ху Зе Жун, БНСУ-ын Аудит болон Хяналт шалгалтын зөвлөлийн дарга ноён Чой Жае Хён нарт Монгол Улсын ҮАГ-аас хамтарсан албан ёсны арга хэмжээний асуудлаар санал хүргүүлж мэдээлэл солилцон, цаашдын хамтын ажиллагааг үр дүнтэй үргэлжлүүлэн ажиллахаар тохиролцоонд хүрэв.

Дэлхийн улс орны ТАБ-уудын Ковид-19 цар тахлын үед авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, цаашдын чиг хандлагын талаар ИНТОСАИ-аас гаргасан зөвлөмж болон харилцагч АДБ-уудын сайн туршлагыг судлах, мэдээлэл солилцох,

мөн уламжлалт харилцааг алдалгүйгээр шинээр үүссэн нөхцөл байдалд тулгуурлан хамтын ажиллагааны үр нөлөөт байдлыг хадгалах бодлого, чиглэлийг баримтлан үйл ажиллагаагаа явууллаа.

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ, САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

Монгол Улсын төсвөөс 2020 оны төсвийн жилд МУЕА-ын төсвийн багцын урсгал зардалд 20.7 тэрбум, хөрөнгийн зардалд 1.0 тэрбум, нийт 21.7 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдсан нь төрийн аудитын байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд бодитой дэмжлэг болж төсвийн зарцуулалт, гүйцэтгэл, үр дүнг хуулийн дагуу тайлагнаж ажиллав.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн батлагдсан төсвийг шууд захирагчид төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хуваарилан төсвийн үр ашигтай зарцуулалтад нягтлан бодох бүртгэлээр болон санхүүгийн тайлагналын хяналтыг хэрэгжүүлсэн.

Тайлант хугацааны нийт төсвийн зарцуулалтын 10.0 тэрбум төгрөг буюу 46.1 хувийг УАГ, 1.9 тэрбум төгрөг буюу 8.8 хувийг Нийслэл дэх

Төрийн аудитын газар, 9.8 тэрбум төгрөг буюу 45.1 хувийг 21 аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус хуваарилсан байна.

Батлагдсан төсвийн 12.8 тэрбум төгрөг буюу 59.2 хувийг үндсэн цалин, нэмэгдэл, урамшууллын зардал, 1.6 тэрбум төгрөг буюу 7.6 хувийг НДШ-ийн зардал, 4.1 тэрбум төгрөг буюу 19.1 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, 2.2 тэрбум төгрөг буюу 9.5 хувийг бусад зардал, 1.0 тэрбум төгрөг буюу 4.6 хувийг хөрөнгийн зардал тус тус эзэлж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн урсгал төсвийн зарцуулалт 19.3 тэрбум төгрөг буюу 93.3 хувь, хөрөнгийн зардлын зарцуулалт 0.9 тэрбум төгрөг буюу 100 хувь, нийт төсвийн зарцуулалт 20.3 тэрбум төгрөг буюу 93.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 3 Батлагдсан төсвийн хэтрэлт, хэмнэлт

Д.д	Зардлын бүлэг	Батлагдсан төсөв		Төсвийн гүйцэтгэл		Төсвийн хэтрэлт, хэмнэлт	
		Урсгал төсөв	Эзлэх хувь	Урсгал төсөв	Эзлэх хувь	Зөрүү (+,-)	Эзлэх хувь
1	Цалин хөлс, нэмэгдэл урамшил	12,837.4	59.2	12,574.9	61.9	262.5	2.0
2	Нийгмийн даатгалын шимтгэл	1,641.7	7.6	1,591.2	7.8	50.5	3.1
3	Байр ашиглалттай холбоотой зардал	181.9	0.8	176.7	0.9	5.2	2.9
4	Хангамж, бараа материалын зардал	496.1	2.3	488.3	2.4	7.8	1.6
5	Эд хогшил, урсгал засварын зардал	224.8	1.0	211.9	1.0	12.9	5.7
6	Томилолт, зочны зардал	301.1	1.4	286.0	1.4	15.1	5.0
7	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, төлбөр, хураамж	4,145.2	19.1	3,302.1	16.3	843.3	20.3
8	Бараа үйлчилгээний бусад зардал	264.7	1.2	122.7	0.6	142.0	53.6
9	Урсгал шилжүүлэг	607.1	2.8	560.0	2.8	47.1	7.8
	ДҮН	20,700.0	95.4	19,313.8	95.1	1,386.2	6.7
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,000.0	4.6	990.0	4.9	10.0	1.0
	НИЙТ ЗАРДАЛ	21,700.0	100	20,303.8	100	1,396.2	6.4

МУЕА-ын төсвийн багцад хамаарах 23 төсвийн шууд захирагчийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, анхан шатны баримт материалыг холбогдох бусад санхүүгийн

баримт бичгийн хамт “Мишээл-Од аудит” ХХК-д хүлээлгэн өгч төсвийн цаглаварт хугацаанд аудитын дүгнэлт гаргах ажлыг гүйцэтгэж байна.

ᠲᠦᠷᠢᠶᠢᠨ ᠠᠭᠳᠢᠲᠤ
ᠬᠥᠭᠵᠢᠯᠢᠶᠢᠨ ᠰᠢᠨᠢᠭᠤᠨ
ᠴᠠᠬᠢᠮ ᠰᠤᠷᠭᠠᠯᠲᠤᠨ
ᠨᠡᠪᠲᠦᠷᠦᠬᠤ



ᠲᠦᠷᠢᠶᠢᠨ ᠠᠭᠳᠢᠲᠤ
ᠬᠥᠭᠵᠢᠯᠢᠶᠢᠨ ᠰᠢᠨᠢᠭᠤᠨ

ᠴᠠᠬᠢᠮ ᠰᠤᠷᠭᠠᠯᠲᠤᠨ

ᠨᠡᠪᠲᠦᠷᠦᠬᠤ

ᠰᠢᠨᠢᠭᠤᠨ

mentor@gmail.com

ᠰᠤᠷᠭᠠᠯᠲᠤ

Сануулэх

ᠨᠡᠪᠲᠦᠷᠦᠬᠤ

4

ДУГНЭЛТ, ЦААШДЫН ЗОРИЛТ

ТЫН СУРГАЛТ,
СТЕМ

СИСТЕМД НЭВТРЭХ ХЭСЭГ

om

Нууц үг мартсан?



ДҮГНЭЛТ

Төрийн аудитын байгууллагаас 2020 онд дэвшүүлсэн “Төрийн аудитын байгууллагын эрх зүйн орчин, стандартын шинэтгэлийн жил”-ийн зорилтыг бүрэн хэрэгжүүлж ажиллалаа.



Монгол Улсын Их Хурлаас баталсан Үндсэн хуулийн өөрчлөлтөд нийцүүлж, УИХ-ын Нэгдсэн чуулганы 2020 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаар Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж, хуулиар тодорхойлсон “Төрийн санхүү, төсвийн хяналт” нь илүү өргөн утга агуулгатай болж төсөв болон төсвийн чиг үүрэг, хариуцлагатай холбоотой аливаа хуулийн этгээдийн санхүү, бүртгэл, нийтийн өмчтэй холбоотой бүхий л үйл ажиллагааг хамруулан аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэх эрх зүйн орчин бүрдлээ.



АДБОУС-ыг Монгол Улсын “Төрийн аудит”-ын /MNS 6817:2020/ стандартаар баталгаажуулж 2020 оны 1 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн албан ёсоор мөрдөж эхэлснээр төрийн аудитын арга зүйг боловсронгуй болж, аудитын чанар, үр нөлөөг дээшлүүлэх чухал алхам боллоо.



Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн 3825, гүйцэтгэлийн 160, нийцлийн 156 буюу нийт 4141 аудит гүйцэтгэж, 12.8 их наяд төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 4.6 их наяд төгрөгийн алдаа зөрчлийг залруулж, зөрчлийг арилгуулах шийдвэр гарган, холбогдох асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүллээ.



Улс, орон нутгийн төсөвт 40.1 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, 359.6 тэрбум төгрөгийн үр өгөөжийг хүлээн зөвшөөрүүлсэн нь төсвийн санхүүжилтийн “Нэг” төгрөг тутамд 18.6 төгрөгийн үр өгөөж бий болсон байна.



Төрийн аудитын байгууллагаас аудитын эрх зүй, стандартын шинэтгэлтэй уялдуулж өөрчлөн сайжруулах бодлогын арга хэмжээг авч, үйл ажиллагааны чиг үүргийн давхардлыг арилгах, аудитын нөөцийг зохистой хуваарилах үндсэн зорилтыг хэрэгжүүлэн 2021 оны үйл ажиллагааны бодлогын зорилтоо тодорхойлж бэлтгэл ажлыг хангаж чадлаа.

ЦААШДЫН ЗОРИЛТ

Төрийн аудитын байгууллагаас өнгөрсөн хугацаанд болон өнөөгийн тулгамдаж буй хэрэгцээ шаардлага, байгууллагынхаа хэтийн стратегийн зорилтод нийцүүлэх, хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэх чиг үүрэг, аудитын үр нөлөөг дээшлүүлэх суурь зарчимд тулгуурлан 2021 оныг "Аудитыг цахимжуулж нэгтгэн удирдах тогтолцоог бүрдүүлж, төлөвшүүлэх" бодлогын жил болгож байна.

Төрийн аудитын байгууллагын цаашдын зорилт нь Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын "Алсын хараа-2050", "Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-ын үзэл баримтлалыг дэмжсэн стратегийн аудитыг гүйцэтгэхэд чиглэгдэх юм.

Төрийн аудитын байгууллагаас 2021 онд баримтлах үндсэн чиглэл



Хууль тогтоомжийн хүрээнд гүйцэтгэх аудитыг их өгөгдөл, мэдээлэлд суурилсан урьдчилсан судалгаанд тулгуурлан аудитын ерөнхий бодлого, чиглэлийг тодорхойлсны үндсэн дээр нэгдсэн удирдлагаар хангах, үр дүнг харилцагч талуудад нэгтгэн тайлагнана.



Төрийн санхүү, төсвийн хяналтыг хэрэгжүүлэх аудитын хэтийн болон жилийн төлөвлөгөөг стратегийн төвшинд тодорхойлох, төрөлжсөн аудитын явц, гүйцэтгэлийн мэдээллийн уялдаа, үр нөлөөт байдлыг хангана.



Шилэн дансны тухай хуулийн дагуу хэрэгжүүлэх аудитын горим, нэгтгэн тайлагнах тогтолцоог төлөвшүүлнэ.



Олон нийтийн хүсэн хүлээсэн, тулгамдсан асуудалд хариулт өгөх үр нөлөө бүхий аудитыг гүйцэтгэхийн тулд мэдээллийн технологийн дэвшилтэт арга хэлбэрийг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн аудитын сургалт, судалгаа, хөгжлийн тогтолцоог нэвтрүүлнэ.



Мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлж шалгагдагч болон холбогдох байгууллагын аудитад шаардлагатай мэдээллийг аливаа этгээдээс хамааралгүйгээр оновчтой сонголт хийх боломжийг бий болгож, үр нөлөөт байдлыг дээшлүүлэх, дүн шинжилгээ хийх ухаалаг тайлангийн системийг бий болгоно.



Төрийн аудитын тасралтгүй, үр дүнг бодитой байлгах зорилгоор бүтцийн нэгжүүдийн хамтын ажиллагаа, уялдааг хангасан, хязгаарлагдмал нөөц бололцоог зүй зохистой ашиглах мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлэх бодлогын хэрэгжилтийг хангаж ажиллана.

تعمیر و نگهداری سیستم های کامپیوتر



5

СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ОРШИЛ

УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны 05 дугаар тогтоолын дагуу Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан удирдамжаар Төрийн аудитын байгууллагын 2020 оны үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийлээ. Үүнд:

- Төрийн аудитын байгууллагын чиг үүргийн хэрэгжилт;
- Төрийн аудитын байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт;
- Хүний нөөцийн хэрэгцээ;
- Санхүү буюу захиргааны зардал;

Системчилсэн үнэлгээг Төрийн аудитын байгууллагын 2020 оны үйл ажиллагааны тайлан, Төрийн аудитын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, хүний нөөцийн судалгаа, 2020 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн болон худалдан авах ажиллагааны тайлан, холбогдох бусад баримт материалд тулгуурлан, үнэлгээ хийх арга зүйн дагуу гүйцэтгэсэн болно.

1. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРЭГ, 2020 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ

1.1. Төрийн аудитын байгууллагатай холбоотой хууль, эрх зүйн талаар

УИХ-аас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийн холбогдох заалтад “Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно” гэж хуульчилсан нь Төрийн аудитын байгууллагын хараат бус байдлыг баталгаажуулах чухал алхам болсон.

УИХ-ын 2020 оны 1 дүгээр сарын 09-ний өдрийн 02 дугаар тогтоолд заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд холбогдох хууль тогтоомжийг нийцүүлэх ажлын хүрээнд Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-д өргөн барьж, 2020 оны 5 дугаар сарын 01-ний өдөр баталж, 2020 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж байна.

Төрийн аудитын байгууллага нь 2020 онд Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллагаас батлан гаргасан, гишүүн орнуудад хүлээн зөвшөөрөгдсөн аудитын бодлого, арга зүй, нийтлэг ашиглагдах стандарт, удирдамжид нийцсэн Төрийн аудитын стандарт MNS 6817:2020-ыг батлуулсан.

Төрийн аудитын байгууллагад 20 гаруй хуулиар аудит хийх чиг үүргийг хариуцуулсан бөгөөд МУЕА-ын тушаалаар тайлант онд нийт 23 дүрэм, журам, заавар, аргачлалыг шинэчлэн боловсруулж баталснаас 12 нь аудитын үйл ажиллагаатай холбоотой журам, заавар, аргачлал байна.

Дээрх хуулийн өөрчлөлттэй холбоотойгоор зарим хууль, тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага тулгарч байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай

1.2. Байгууллагын зорилго, зорилтууд

Төрийн аудитын байгууллагын стратегийг МУЕА-ын 2019 оны А/76-1 дугаартай “Төрийн аудитын байгууллагын стратегийг батлах тухай” тушаалаар баталсан байна.

Стратегийн зорилгыг тодорхойлохдоо “Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааг хараат бусаар явуулах эрх зүйн болоод арга зүй, технологийн таатай орчныг бүрдүүлэх”-ээр тусгаж үндсэн 6 зорилтын хүрээнд 35 арга хэмжээ, тэдгээрийн гүйцэтгэлийн хэмжүүрийг тодорхойлж төлөвлөжээ.

Төрийн аудитын байгууллага стратегийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг тогтмолжуулах, хяналтын тогтолцоог бүрдүүлэх зорилгоор МУЕА-ын 2020 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн А/02 дугаар тушаалаар Үндэсний аудитын газрын бүтцэд өөрчлөлт оруулж Дотоод аудитын албыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар болгон өргөтгөн зохион байгуулж холболдох чиг үүргийг хариуцуулсан.

Төрийн аудитын байгууллага нь харилцагч талуудтай харилцах харилцааг сайжруулж, оролцоог хангах үүднээс илүү системтэй арга хэлбэрээр Төрийн аудитын байгууллагын хэрэгжүүлэх богино ба дунд хугацааны стратегийн дагуу тодорхой ажлуудыг хэрэгжүүлж байна. Тухайлбал,

- Төрийн аудитыг гүйцэтгэхэд шалгагдагч хуулийн этгээд, хүний хүчин зүйлсээс хамааралгүйгээр оновчтой сонголт хийх боломжийг бий болгож, аудитын үр нөлөө, үйл ажиллагааны үр ашигтай байдлыг дээшлүүлэх, урьдчилсан судалгаа, их өгөгдөлд суурилсан дүн шинжилгээ хийх ухаалаг тайлангийн дэд системийн хөгжүүлэлтийг хийж байна.
- ТАБ-ын хувьд 2020 он цахим сургалт, хөгжлийн нэгдсэн системийг боловсруулан хөгжүүлэлт хийн сургалт эхлүүлэх бэлтгэл ажлын хангаснаар ТАБ-ын нийт албан хаагчдыг хамруулж 94 хувь амжилттай дүгнэгдсэн байна.
- Үндэсний аудитын газар нь “Ковид-19” цар тахлын үед хэрэгжүүлэх “Тогтвортой үйл ажиллагааны төлөвлөгөөг Аудитын дээд байгууллагаас гаргасан зөвлөмж, сайн туршлагад үндэслэн боловсруулж МУЕА-ын 2020 оны А/105 дугаар тушаалаар баталж, хэрэгжүүлж ажилласан нь гамшгийн үеийн байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй, хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

1.3. Төрийн аудитын байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар

Төрийн аудитын байгууллагын хэмжээнд 2020 оныг “Төрийн аудитын байгууллагын эрх зүйн орчин, стандартын шинэтгэлийн жил” болгох зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Санхүүгийн тайлангийн 3825, гүйцэтгэлийн 160, нийцлийн 156, нийт 4141 аудит гүйцэтгэж 12.8 их наяд төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 4.6 их наяд төгрөгийн алдаа зөрчлийг аудитын явцад залруулж, 8.2 их наяд төгрөгийн алдаа зөрчлийг арилгуулах аудитын шийдвэр гарган ажиллажээ.

МУЕА-ын 2020 оны 3 дугаар сарын 06-ны өдөр баталсан Төрийн аудитын байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 бүлгийн хүрээнд 114 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд биелэлтийг жилийн эцсийн байдлаар нэгтгэн дүгнэхэд 91.0 хувийн гүйцэтгэлтэй гарсан нь цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалсан байна.

2. ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭРЭГЦЭЭНД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ

УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны 01 дүгээр тогтоолыг үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны “Үндэсний аудитын газрын зохион байгуулалтын бүтэц, бүтцийн нэгжүүдийн үндсэн үйл ажиллагааны чиг үүрэг, орон тоо, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” А/02 дугаар тушаалыг батлан хэрэгжүүлж, тус тушаалын дагуу 394 албан хаагч, 7 газар, 1 хэлтэс, аймаг, нийслэлд Төрийн аудитын 22 газар чиг үүргээ гүйцэтгэж байна.

Төрийн аудитын байгууллага нь батлагдсан орон тооны дээд хязгаар болох 394 албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулснаас УАГ-т 115, аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газарт 279 албан хаагч ажилласан бөгөөд ажлын ачаалал их, хүний нөөцийн дутагдалтай байдлаас шалтгаалан тайлант онд 41 гэрээт ажилтан авч ажиллуулсан байна.

Аймаг дахь Төрийн аудитын газрууд хүний нөөцийн дутагдлаас үүдэн төрөлжсөн аудитын чиглэлээр ажиллах боломжгүй, аудиторууд бүх төрлийн аудитад оролцож байна. Орон нутагт гүйцэтгэл болон нийцлийн аудитын багт нарийн мэргэжлийн мэргэшсэн /инженер, барилга, замын мэргэшсэн төсөвчин гэх мэт/ ажилтныг гэрээгээр авч ажиллуулах асуудал төсөв, санхүүгээс хамааран орхигдсон байна.

Албан хаагчдын 2020 онд илүү цагаар ажилласан бүртгэлээс зөвхөн Үндэсний аудитын газрын албан хаагчдын хувьд авч үзэхэд нийт албан хаагчдын 31 хувь нь илүү цагаар ажиллаж нэг албан хаагч 7 хоногийн ажлын 5 өдөрт 40 цаг ажиллахаас гүйцэтгэлээр 60-70 цаг байгаа нь хүний нөөцийн хувьд дутагдалтай ажилласныг харуулж байна.

Төрийн аудитын байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүний нөөц шаардлагатай байгааг үндэслэн УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2020 оны 06 дугаар тогтоолоор Төрийн аудитын байгууллагын орон тооны хязгаарыг өөрчлөн баталсны дагуу зохион байгуулалт, бүтэц, орон тоо, чиг үүргийн өөрчлөлтийг 2021 оноос зохион байгуулж мөрдүүлэхээр зорилт дэвшүүлэн үе шаттайгаар хэрэгжүүлж эхлээд байна.

Төрийн аудитын байгууллагын 2020 оны батлагдсан орон тооны бүтцийг авч үзвэл дараах байдалтай байна.

АНТАГ орон тоо	Үүнээс				УАГ орон тоо	Үүнээс			
	Аудитад оролцдог		Удирдлага, дэмжих үйлчилгээ			Аудитад оролцдог		Удирдлага, дэмжих үйлчилгээ	
	тоо	хувь	тоо	хувь		тоо	хувь	тоо	хувь
279	227	82.0	52	18.0	115	89	77.0	26	23.0

Хүснэгтэд үзүүлснээр Төрийн аудитын байгууллагын хувьд албан хаагчдын 80 хувь нь аудитын үйл ажиллагаанд оролцож, 20 хувь нь дэмжих үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

3. САНХҮҮ БУЮУ ЗАХИРГААНЫ ЗАРДЛЫН ҮНЭЛГЭЭ

3.1. Төсвийн төлөвлөлтийн талаар

Төрийн аудитын байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 25.5 тэрбум төгрөгөөр төлөвлөж, зарцуулахаар тооцон Сангийн яаманд хүргүүлсэн байна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 3.8 тэрбум төгрөгөөр бууруулж, төсвийг 21.7 тэрбум төгрөгөөр баталсан байна.

3.2. Төсвийн гүйцэтгэлийн талаар

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1¹-д заасны дагуу Төрийн аудитын байгууллагын 2020 оны төсөвт урсгал санхүүжилтэд 20.7 тэрбум, хөрөнгийн зардалд 1.0 тэрбум, нийт 21.7 тэрбум төгрөг батлагдсан байна.

МУЕА-ын 2020 оны төсөв нэмэгдсэн нь ТАБ-ын албан хаагчдын үндсэн цалингийн хэмжээг УИХ-ын 2019 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн нэгдсэн чуулганаар шинэчлэн тогтоосон цалингийн зардал, УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2019 оны 05 дугаар тогтоолоор баталсан "ТАБ-ын 2020 онд хийж гүйцэтгэх аудитын сэдэв"-ийн дагуу гүйцэтгэл, нийцлийн аудитад нарийн мэргэжлийн зөвлөх, шинжээч, хуулийн этгээд татан оролцуулж ажиллуулах зардлыг тусгасантай холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэлээр 20.4 тэрбум төгрөг буюу 93.6 хувийг зарцуулж 1.3 тэрбум төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант онд Үндэсний аудитын газрын хэмжээнд урсгал зардалд нийт 9.9 тэрбум төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 8.9 тэрбум төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 10.9 хувь буюу 1.0 тэрбум төгрөгөөр хэмнэсэн байна.

Нийт зардлын 48.8 хувийг ажиллагсдын цалин хөлс болон НДШ-ийн зардалд, 32.0 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт, 11.1 хувийг хөрөнгийн зардалд, 2.4 хувийг хангамж, бараа материалын зардалд, 2.3 хувийг урсгал шилжүүлгийн зардалд, 1.5 хувийг томилолт зочны зардалд, 0.9 хувийг бараа үйлчилгээний бусад зардалд, 0.8 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд, 0.2 хувийг эд хогшил, урсгал засварын зардалд тус тус зарцуулсан байна.

Батлагдсан төсвийг гүйцэтгэлтэй харьцуулбал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 812.2 сая, бараа үйлчилгээний бусад зардал 137.4 сая, цалин хөлсний зардал 79.5 сая, урсгал шилжүүлэг 45.2 сая, хөрөнгийн зардал 10.0 сая, бусад зардлыг 1.5 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

3.3. Санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэлийн талаар

МУЕА-ын 2020 оны А/100 дугаар тушаалаар "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг", А/101 дүгээр тушаалаар "Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ыг батлан Төсвийн Ерөнхийлөн захирагчийн төсөв санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөн ажилласан байна. Мөн Төрийн аудитын байгууллагын ажилтнуудад "Албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам", "ТАБ-ын албан хаагчдад улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох журам", "Унаа хоолны хөнгөлөлт олгох журам"-ыг шинээр батлан хэрэгжүүлжээ.

Санхүүгийн тайлангаар эргэлтийн хөрөнгө өмнөх оноос 556.7 сая төгрөгөөр нэмэгдэж 1,345.4 сая төгрөгт хүрсэн байна. Эргэлтийн хөрөнгийн бүтцийг урьд оны мөн үетэй харьцуулбал мөнгөн хөрөнгө 174.1 сая төгрөгөөр, авлага 211.1 сая, урьдчилгаа 240.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

¹ 8.1 Үндэсний аудитын газрын төсвийг түүний саналыг үндэслэн УИХ хэлэлцэн батална. Төсөв нь УАГ үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байна.

Тайлант оны жилийн эцсийн байдлаар авлага дансны үлдэгдэл 645.6 сая төгрөг болж 211.2 сая төгрөгөөр, өр төлбөрийн дансны үлдэгдэл 767.1 сая төгрөг болж 390.3 сая төгрөгөөр тус тус өссөн нь МУЕА-ын 2017 оны А/191 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу хараат бус аудитын хуулийн этгээдийн гүйцэтгэсэн аудитын төлбөрийг нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан авч, хуваарилж байгаагаас шалтгаалан үүссэн байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 432.2 сая төгрөг болж 240.0 сая төгрөгөөр өссөн нь төрийн өмчит компаниудын санхүүгийн тайланг баталгаажуулахад ажиллуулсан аудитын хуулийн этгээдэд олгосон зардал байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,002.8 сая төгрөг болж 1,301.1 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд шинээр худалдан авсан хөрөнгийн өсөлтөөс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь хөрөнгийн санхүүжилтээр 990.0 сая, урсгал санхүүжилтээр 1,155.0 сая, балансаас балансад үнэ төлбөргүй шилжиж ирсэн 165.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, 50.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоолын дагуу акталсан байна. Дуусаагүй барилга байгууламж дансанд 100.0 сая төгрөгийн үлдэгдэл урьд оноос шилжин бүртгэгдсэн байна.

ҮАГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг УИХ-ын даргын 2021 оны 2 дугаар сарын 03-ны 10 дугаар захирамжаар томилогдсон "Мишээл од аудит" ХХК гүйцэтгэж санхүүгийн тайланд "Зөрчилгүй" дүгнэлт гаргасан байна.

3.4. Шилэн дансны талаар

Тайлант хугацаанд байршуулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа байршуулсан 137 мэдээлэл, хугацаа болоогүй 6 мэдээлэл, хугацаа хоцроосон 3 мэдээлэл, шилэн дансны цахим системд байршуулаагүй 3 мэдээлэл байна. Мөн худалдан авалттай холбоотой гэрээний мэдээллийг дутуу байршуулсан байна.

3.5. Худалдан авах ажиллагааны талаар

ҮАГ-ын хэмжээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1,000.0 сая, үндсэн үйл ажиллагааны урсгал зардлаас 3,033.5 сая, нийт 4,033.5 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий нийт 35 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөгөөг баталсан байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулан 2,476.4 сая төгрөгийн 23 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 2,379.8 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна.

Нийт худалдан авах ажиллагааны 17 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг цахим тендерийн системээр, 6 төсөл арга хэмжээг уламжлалт аргаар зарлаж зохион байгуулжээ.

Төрийн аудитын дээд байгууллага нь 1998 оноос хойш Засгийн газрын 4 дүгээр байранд байрлаж ирсэн. Мэргэжлийн хяналтын байгууллагаас Төрийн аудитын дээд байгууллагын үйл ажиллагаагаа явуулж буй тус байр нь ашиглалтын хугацаа дууссан гэх дүгнэлт гарсан бөгөөд энэ нь урсгал засварын зардалд нөлөөлж байна. Иймд бие даасан, хараат бус байх нөхцөлийг бүрдүүлж, өөрийн байртай болох асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх шаардлагатай гэж үзлээ.

ДҮГНЭЛТ

Системчилсэн үнэлгээний явцад цуглуулсан нотлох зүйл, үнэлгээний дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Төрийн аудитын байгууллага жилийн үйл ажиллагааны тайлангаа нэгдүгээр улиралд багтаан УИХ-д хүргүүлэхээр Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан нь Төсвийн тухай хуульд төсвийн ерөнхийлөн захирагч аудит хийгдсэн санхүүгийн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 25-ны дотор Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх заалттай уялдаагүй байна.
- “Ковид-19” цар тахлын үед цахим сургалт, хөгжлийн нэгдсэн системийг боловсруулан хөгжүүлэлт хийн сургалт эхлүүлэх бэлтгэл ажлыг хангаж, цаг алдалгүй хүний нөөцөө сургах ажлыг зохион байгуулан нийт албан хаагчдыг хамруулж 94 хувийн амжилттай дүгнэгдсэн байна.
- Төрийн аудитыг гүйцэтгэхдээ шалгагдагч этгээдийг хүний хүчин зүйлсээс хамааралгүйгээр оновчтой сонголт хийх боломжийг бий болгож, аудитын үр нөлөө, үйл ажиллагааны үр ашигтай байдлыг дээшлүүлэх, урьдчилсан судалгаа, их өгөгдөлд суурилсан дүн шинжилгээ хийх ухаалаг тайлангийн дэд системийн хөгжүүлэлтийг эхлүүлсэн байна.
- МУЕА-ын 2020 оны А/105 дугаар тушаалаар гамшгийн үед хэрэгжүүлэх “Тогтвортой үйл ажиллагааны төлөвлөгөө”-г батлан хэрэгжүүлж ажилласан нь үйл ажиллагааны тасралтгүй, хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байна.
- УИХ-ын даргын 2021 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн 10 дугаар захирамжаар томилогдсон “Мишээл од аудит” ХХК УАГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэж “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.
- Сүүлийн жилүүдэд нийгэм, эдийн засагт нөлөө бүхий томоохон төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтын гэрээ, хэлэлцээрт аудит хийж байгаа тул олон улсын хөрөнгө оруулалтын салбар чиглэлээр аудиторудыг мэргэшүүлэх, албан хаагчдын хараат бусаар ажиллах нөхцөл баталгааг нэмэгдүүлэн, төрөөс нийгмийн хамгааллын чиглэлээр дэмжлэг үзүүлж, мэргэшсэн, тогтвортой ажиллуулах бодлогын өөрчлөлтөд анхаарах шаардлагатай байна.
- Үндэсний аудитын газрын байр ашиглалтын талаар гаргасан мэргэжлийн байгууллагын дүгнэлт, төрийн аудитын үйл ажиллагааны хараат бус, бие даасан байдлыг хангахуйц байрны нөхцөл, хүрэлцээ хангамжийг сайжруулах чиглэлээр бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

مجلس المدینة العلمیة



6

САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ӨГСӨН
ХАРААТ БУС
АУДИТОРЫН
ДҮГНЭЛТ



“МИШЭЭЛ-ОД АУДИТ” ХХК

Нягтлан бодох бүртгэл- Аудит, Баталгаажуулалт,
Аутсорсингийн үйлчилгээ, Бизнесийн зөвлөгөө өгөх

2021.03.09 № А/67

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Үндэсний аудитын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Үндэсний аудитын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар Үндэсний аудитын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Аудитын хүрээнд бусад асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

“МИШЭЭЛ-ОД АУДИТ” ХХК-ийн
ЗАХИРАЛ Т.ОДОНЧИМЭГ

2021 оны 03 дугаар сарын 09-ны өдөр



ХАВСРАЛТ 1 ҮЙЛ ЯВДЛЫН ТОВЧООН

Сар	Үйл явдлын товч агуулга
I	<ul style="list-style-type: none"> “Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт”-ыг Үндэсний аудитын газар болон Стандарт, хэмжил зүйн газартай хамтран Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн шаардлагад нийцүүлэн Төрийн аудитын стандартыг баталгаажууллаа. ОХУ-аас Монгол Улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд И.К.Азизов ОХУ-ын Тооцооны танхимын даргын захидлыг МҮЕА Д.Занданбатад гардуулан өгч, хамтарсан аудитыг гүйцэтгэх асуудлаар санал солилцов.
II	<ul style="list-style-type: none"> Үндэсний аудитын газар Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институттэй хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр санал солилцох уулзалт зохион байгуулав. МҮЕА-ын орлогч О.Тэнгис “Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага”-ын төлөөлөгчдийг хүлээн авч уулзав. Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд нэг нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээ тогтоолоо.
III	<ul style="list-style-type: none"> Хууль санаачлагчдаас Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг өргөн барив. ҮАГ-ын хамт олноос хандив цуглуулан Улсын онцгой комисст хүлээлгэн өгөв. АНТАГ-уудын тэргүүлэх аудитор, менежерүүдийг оролцуулан ёс зүйн хэм хэмжээг сахих, ашиг сонирхлын зөрчилд орохгүй байх сэдвээр “Цахим” хуралдааныг зохион байгуулав.
IV	<ul style="list-style-type: none"> Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвслийн мөрийн хөтөлбөрт хийх аудитыг хуулийн хугацаанд дуусгав.
V	<ul style="list-style-type: none"> Монгол Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар Төрийн аудитын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг баталлаа. УИХ-ын Төсвийн байнгын хорооны хуралдаанаар Төрийн аудитын байгууллагын 2019 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцлээ. УИХ-ын Төсвийн байнгын хорооны хуралдааны 04 дүгээр тогтоолоор Үндэсний аудитын газрын 2020 онд гүйцэтгэх аудитын сэдвийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан тухай, 05 дугаар тогтоолоор Үндэсний аудитын газрын 2021 онд гүйцэтгэх аудитын сэдвийн төлөвлөгөөг баталлаа. “Монгол Улсын Их Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам” боловсруулан баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэв. Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах аудитыг хуулийн хугацаанд дуусгав. УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2020 оны 06 дугаар тогтоолоор Төрийн аудитын байгууллагын орон тоог шинэчлэв.

Сар	Үйл явдлын товч агуулга
VI	<ul style="list-style-type: none"> Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд БНХАУ, БНСВУ, БНСУ-ын Аудитын дээд байгууллагын удирдлагуудтай мэдээлэл солилцов.
IX	<ul style="list-style-type: none"> МУЕА-ын орлогч О.Тэнгис АНУ-ын Элчин сайдын яамны төлөөлөгчтэй уулзалт хийн харилцаа, хамтын ажиллагааны талаар санал солилцов. “Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн”-д хийх гүйцэтгэлийн аудитын нээлт болов. ҮАГ-ын удирдлагууд аудитын хуулийн этгээд болох нийт 95 компанийн төлөөллийг хүлээн авч, ТАБ-ын бодлого, аудитын чанарын асуудлаар уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулав. Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын аудитыг дуусган тайланг нийтлэв. ҮАГ-аас 2021 оны нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт гаргах ажлын хүрээнд эрдэмтэд судлаачидтай уулзалт зохион байгуулав. Монгол Улсын ҮАГ болон БНХАУ-ын Аудитын дээд байгууллагатай хамтран “Санамж бичиг”-ийн ҮАГ-ын ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх цахим сургалтыг зохион байгуулав.
X	<ul style="list-style-type: none"> ҮАГ-ын удирдлагууд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн төлөөлөгчидтэй уулзалт хийв. “Оюутолгой төсөлд оруулсан хөрөнгө оруулалт, санхүүжилтийн зарцуулалт, үр нөлөө”-нд хийх гүйцэтгэлийн аудитын нээлт хийв. Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвслийн сонгуулийн зардлын аудитыг дуусган тайланг нийтлэв.
XI	<ul style="list-style-type: none"> ҮАГ-ын удирдлагууд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн төлөөлөгчидтэй уулзалт хийв. “Оюутолгой төсөлд оруулсан хөрөнгө оруулалт, санхүүжилтийн зарцуулалт, үр нөлөө”-нд хийх гүйцэтгэлийн аудитын нээлт хийв. Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвслийн сонгуулийн зардлын аудитыг дуусган тайланг нийтлэв.

ХАВСРАЛТ 2

АУДИТЫН ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ (2016-2020 ОНЫ БАЙДЛААР)

Д.д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
1	1 төгрөгт ногдох үр өгөөж	төг	67.9	198.6	72.1	26.9	18.6
2	Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн орлого	тбм.төг	7.6	13	15.2	40.6	40.1
3	Тогтоосон төлбөрийн акт	тоо	1,475	1,249	1,955	1,687	1,934
		тбм.төг	10.9	22.4	57.4	19.3	43.1
		тбм.төг	5.1	11	21.5	13.2	17.9
4	Өгсөн албан шаардлага	тоо	2,981	2,152	2,871	2,897	3,313
		тбм.төг	1,173.6	2,537.9	2,202.7	1,991.9	2,297.6
		тбм.төг	837.5	1,796.6	434.0	775.1	421.9
5	Өгсөн зөвлөмж	тоо	7,855	7,694	9,083	7,524	9,890
		тоо	5,685	5,963	7,368	6,160	8,652
6	Илрүүлсэн алдаа зөрчил	тбм.төг	16,336.9	11,477.9	18,831.4	9,057.0	12,848.7
		тбм.төг	6,074.3	2,241.5	12,162.1	1,535.9	4,653.7
7	Албан тушаалтанд хариуцлага тооцуулсан санал	тоо	752	447	617	901	560
8	Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	тоо	186	72	75	96	72
9	Хүлээн зөвшөөрөгдсөн үр өгөөж	тбм.төг	633.7	1,831.6	821.7	406.5	359.6

ХАВСРАЛТ 3

2020 ОНД БОЛОВСРУУЛСАН ДҮРЭМ ЗААВАР, АРГАЧЛАЛ

Д.д	Дүрэм журмын нэр	Батлагдсан огноо	Баримтын индекс
1	Төрийн аудитын байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах	2020.01.31	A/20
2	Заавар батлах тухай /Нам, эвслээс ирүүлсэн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргах заавар, "Хандивын тайлангийн дүгнэлт" загвар	2020.03.16	A/29
3	Аргачлал батлах тухай /Монгол Улсын Их Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл, болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт аудит хийж, дүгнэлт гаргах аргачлал/	2020.03.20	A/32
4	Албан хаагчдад илүү цагийн нэмэгдэл хөлс олгох журам батлах тухай	2020.04.24	A/38
5	Журам, маягт, загвар батлах тухай /МУИХ-ын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам/	2020.05.21	A/45
6	Аргачлал батлах тухай /Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны ээлжит сонгуульд нэм, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох аргачлал	2020.06.10	A/52
7	Заавар, аргачлал батлах тухай /Сонгуулийн зардлыг тайлагнах заавар, аргачлал батлах тухай/	2020.06.12	A/55
8	Аргачлал батлах тухай /Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт аудит хийж, дүгнэлт гаргах аргачлал/	2020.06.16	A/56
9	Журам батлах тухай /Улс төрийн нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт аудит хийж, дүгнэлт гаргахад мэдээллийг нууцлах, хамгаалах журам/	2020.06.26	A/58
10	Түр журам батлах тухай /Төрийн аудитын байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний түр журам/	2020.06.29	A/60
11	Журам батлах тухай /Төрийн аудитын байгууллагын дотоод аудитын журам/	2020.06.29	A/61
12	Төрийн аудитын байгууллагын албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам батлах тухай	2020.07.01	A/63
13	Журам батлах тухай /Төрийн аудитын байгууллагын албан хаагчдад улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох тухай/	2020.07.01	A/65
14	Журам батлах тухай /Төрийн аудитын байгууллагын цахим сургалтыг зохион байгуулахад баримтлах түр журам/	2020.07.10	A/69
15	Журам батлах тухай /Санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдийн ажлын гүйцэтгэлийг хянах, үнэлэх, баталгаажуулах журам/	2020.10.23	A/81
16	Журам батлах тухай /Шинжээч сонгон шалгаруулах гэрээ байгуулах, дүгнэх гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам/	2020.10.23	A/82
17	Загвар маягт батлах тухай /Шинжээч, (шинжээч/санхүүгийн тайлангийн аудит гүйцэтгэх хуулийн этгээд)-ийн ажлын даалгавар"-ын загвар, "Шинжээч сонгох саналын жишиг баримт бичиг"-ийн загвар	2020.12.04	A/92
18	Журам батлах тухай /Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх журам/	2020.12.09	A/93
19	Журам батлах тухай /Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам/	2020.12.09	A/95
20	Журам батлах тухай /Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"	2020.12.16	A/100
21	Журам батлах тухай /Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны журам"	2020.12.16	A/101
22	Дүрэм, журам батлах тухай /"Төрийн аудитын байгууллагын дэргэдэх Ахмадын хорооны дүрэм", "Ахмадын сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах журам"	2020.12.16	A/102
23	Журам батлах тухай /Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам/	2020.12.22	A/106

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ

2020 ОНД ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТЫН ҮР ДҮН

УЛИРЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

ДҮГНЭЛТ ЗОРИЛТ

СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЛАН

ХАРААТ БҮС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ХАВСРАЛТ

ХАВСРАЛТ 4 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

№	Байгууллагын нэр, ангилал	Аудитын илрүүлэлт				Зөвлөмж
		илрүүлсэн		залруулсан		
		тоо	Дүн /сая төг/	тоо	Дүн /сая төг/	тоо
Улсын Төсвийн ерөнхийлөн захирагч						
1	Авилгатай тэмцэх газар	1	2.8	1	2.8	-
2	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	179	17,878.1	52	15,231.0	74
3	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд	536	131,326.5	143	50,736.1	261
4	Барилга, хот байгуулалтын сайд	26	3,706.3	4	2,003.9	18
5	Батлан хамгаалахын сан	160	18,822.7	16	1,566.8	97
6	Гадаад харилцааны сайд	48	7,682.2	16	3,162.4	26
7	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	24	468.0	6	67.2	17
8	Зам, тээврийн хөгжлийн сайд	259	109,705.3	36	82,119.5	161
9	Монгол Улсын дээд шүүх	4	80.1	-	-	4
10	Монгол Улсын ерөнхий прокурор	88	602.6	11	200.7	51
11	Монгол Улсын ерөнхий сайд	143	551,450.8	28	533,710.2	80
12	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар	13	77.8	1	2.3	12
13	Нийгмийн даатгалын сан	139	122,363.4	18	401.8	89
14	Сонгуулийн ерөнхий хороо	4	36.5	-	-	4
15	Санхүүгийн зохицуулах хороо	6	63.7	-	-	6
16	Сангийн сайд	352	516,648.8	103	289,762.5	193
17	Төрийн албаны зөвлөл	5	25.1	-	-	3
18	Улсын Их Хурал	2	5.0	-	-	2
19	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	157	3,040,575.6	43	791,158.7	76
20	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл	7	470.4	1	26.4	4
21	Үндэсний аудитын газар	31	386.4	11	113.8	20
22	Үндэсний статистикийн хороо	40	280.4	21	91.9	13
23	Үндсэн хуулийн цэц	6	42.4	-	-	4
24	Хууль зүй, дотоод хэргийн сайд	429	48,127.3	59	28,682.0	263
25	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	488	126,042.1	73	81,575.5	266
26	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	191	27,743.0	34	20,953.2	106
27	Хүний эрхийн үндэсний комисс	4	16.6	-	-	3
28	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комисс	4	82.1	-	-	3
29	Монгол Улсын шадар сайд	281	18,276.2	62	15,732.9	145
30	Шүүхийн ерөнхий зөвлөл	77	1,418.1	16	623.3	42
31	Эрүүл мэндийн даатгалын сан	29	265,053.6	5	142,223.8	17
32	Эрүүл мэндийн сайд	447	13,971.2	-	-	274
33	Эрчим хүчний сайд	205	1,073,095.2	62	1,059,562.5	115
	Дүн	4,385	6,096,526.1	822	3,119,711.2	2,449

№	Байгууллагын нэр, ангилал	Аудитын илрүүлэлт				Зөвлөмж
		илрүүлсэн		залруулсан		
		тоо	Дүн /сая төг/	тоо	Дүн /сая төг/	тоо
Орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагч						
1	Архангай	344	10,435.4	77	3,660.3	105
2	Баян-Өлгий	286	8,923.0	33	1,669.7	172
3	Баянхонгор	526	9,245.5	63	3,853.5	239
4	Булган	488	2,510.4	42	719.7	274
5	Говь-Алтай	396	13,669.3	105	6,375.6	8
6	Говьсүмбэр	375	5,421.2	174	2,839.0	124
7	Дархан-Уул	423	66,409.6	146	58,710.5	241
8	Дорноговь	797	207,447.9	465	202,065.3	235
9	Дорнод	357	13,586.4	58	2,413.2	127
10	Дундговь	388	2,988.8	99	2,015.0	4
11	Завхан	402	8,302.1	162	4,650.4	186
12	Орхон	404	14,232.7	116	12,823.7	196
13	Өвөрхангай	243	3,190.6	88	2,144.1	104
14	Өмнөговь	511	21,962.4	201	17,244.2	246
15	Сүхбаатар	287	5,009.0	22	2,259.8	56
16	Сэлэнгэ	542	9,719.0	164	6,171.8	143
17	Төв	917	25,507.3	226	10,748.3	454
18	Увс	156	1,683.1	69	1,368.3	50
19	Ховд	550	20,430.5	164	12,097.0	319
20	Хөвсгөл	452	8,258.4	28	3,001.0	348
21	Хэнтий	386	9,002.6	112	4,690.8	183
22	Нийслэл	1,355	125,119.6	471	96,691.8	723
	Дүн	10,585	593,054.9	3,085	458,213.0	4,537

АЙМАГ, НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРААС ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

Д.д	Аудитын газар	Аудитын сэдэв
1	Архангай	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үр дүнд ажлын байр нэмэгдсэн байдал /2018-2019/
2	Архангай	Орон нутгийн төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг
3	Архангай	"Архангайд үйлдвэрлэв" ААТОНӨҮГ-ын 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийх эрсдлийн аудит
4	Архангай	"Цөм сүргийн үржлийн төв" ААТОНӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан дахь өмч хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, хамгаалалт
5	Баян-Өлгий	Мэргэжлийн хяналтын газрын 2018, 2019 оны үйл ажиллагааны үр дүн
6	Баян-Өлгий	Сум хөгжүүлэх сангийн зарцуулалтад хийгдсэн аудитын мөрөөр хийсэн ажлын үр дүнд давтан аудит хийх
7	Баян-Өлгий	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын үйл ажиллагааны үр дүн /2017-2019/
8	Баянхонгор	Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны төсвийн гүйцэтгэл
9	Баянхонгор	ЖДҮДС-аас олгосон зээлийн зарцуулалт, үр дүн /2017-2019/
10	Булган	Аймгийн төсөв, сангийн 2019 оны хөрөнгө оруулалтын үр дүн
11	Булган	Аймгийн ЖДҮДС-гийн хөрөнгийн зарцуулалт
12	Булган	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн 2019 оны үйл ажиллагааны үр дүн
13	Говь-Алтай	Орон төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт
14	Говь-Алтай	Аймгийн хэмжээний усны эрэлт, нийлүүлэлт, хөрөнгө оруулалтын өнөөгийн үнэ цэнэ /2017-2020/
15	Говь-Алтай	Орон нутгийн өмчийн 2018-2020 онд дуудлага худалдааны хураамжийн төвлөрүүлэлт, зарцуулалт
16	Говьсүмбэр	Орон нутгийн төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг
17	Говьсүмбэр	Соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн
18	Говьсүмбэр	Байгаль орчин аялал жуулчлалын газрын үйл ажиллагааны үр дүн
19	Дархан-Уул	"Дархан Дулааны Сүлжээ" ТӨХК-ийн 2018, 2019 оны үйл ажиллагаа, үр дүн
20	Дархан-Уул	Эрүүл мэндийн газрын 2018, 2019 оны үйл ажиллагаа, үр дүн, үр нөлөө
21	Дархан-Уул	Онцгой байдлын газрын 2018, 2019 оны үйл ажиллагаа, үр дүн
22	Дорноговь	Орон нутгийн төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн
23	Дорноговь	Мэргэжлийн боловсрол олгох үйл ажиллагааны үр дүн
24	Дорнод	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа мэргэжлийн боловсролын болон их дээд сургуулиудын үйл ажиллагааны үр дүн
25	Дундговь	Төлбөрийн баримт олголт, үр дүн
26	Дундговь	Аймаг хөгжүүлэх бодлого төлөвлөлт, түүний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө
27	Дундговь	Мал аж ахуйн салбарын бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн

Д.д	Аудитын газар	Аудитын сэдэв
28	Завхан	Дөрвөлжин сумын төсөвт байгууллагуудын 2019 оны үйл ажиллагааны үр дүн
29	Завхан	Нийгмийн халамж болон хөдөлмөр эрхлэлтийн сангуудын 2019 оны үйл ажиллагааны үр дүн
30	Завхан	Орон нутгийн татварын нэр төрлүүдийн төлөвлөлт, гүйцэтгэлийн үр дүн
31	Орхон	Орон нутагт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилт үр дүн
32	Орхон	Орон нутгийн төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг
33	Орхон	Орон нутгийн өмчийн ашиглалт хамгаалалт, бүртгэлийн явц байдал
34	Өвөрхангай	Орон нутгийн төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн
35	Өвөрхангай	"Баянтээг" ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны үр дүн
36	Өвөрхангай	Орон нутгийн 2021 оны төсвийн төсөлд төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, орлого нэмэгдүүлэх талаар санал боловсруулж ИТХ-д оруулах дүгнэлт өгөх
37	Өмнөговь	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн
38	Сүхбаатар	"Дөрвөлж" ОНӨҮГ-ын үйл ажиллагааны үр дүн /2017-2018/
39	Сэлэнгэ	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2019 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө
40	Сэлэнгэ	Баянгол сумын төр, төсвийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн
41	Төв	"Төв Чандмань ДЭХГ" ОНӨҮГ-ын үйл ажиллагаа үр дүн
42	Төв	Орон нутгийн төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн, үр ашиг
43	Увс	Гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагааны үр дүн
44	Увс	Эргэлтийн эмийн сангийн 2017-2019 оны үйл ажиллагааны үр дүн
45	Ховд	Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн ногдуулалт, төлөлтийн байдал
46	Ховд	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр хураамжийн төлөвлөлт, бүрдүүлэлтийн үр дүн
47	Ховд	"Ховд Дулааны станц" ТӨХК-ийн үйл ажиллагаа
48	Хөвсгөл	"Хөвсгөл Дулааны станц" ТӨХК-ийн 2018-2019 оны үйл ажиллагааны үр дүн
49	Хөвсгөл	"Могойн гол" ХК-ийн 2018-2019 оны үйл ажиллагааны үр дүн
50	Хэнтий	Орон нутгийн төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг
51	Нийслэл	Дүүргийн төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг
52	Нийслэл	Нийслэлийн төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг
53	Нийслэл	"Багачууд хүнс", "Өсвөр үе хүнс", "Асгат", "Хүнс хангамж төв" ОНӨААТҮГ-уудын 2017-2019 оны үйл ажиллагааны үр дүн
54	Нийслэл	Нийслэлийн зураг төсвийн хүрээлэнгийн 2017-2019 оны үйл ажиллагааны үр дүн

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ

2020 ОНД ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТЫН ҮР ДҮН

УЛИРЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

ДҮГНЭЛТ ЗОРИЛТ

СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЛАН

ХАРААТ БҮС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ХАВСРАЛТ

ХАВСРАЛТ 6


АЙМАГ, НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРААС ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТ

№	Аудитын газар	Аудитын сэдэв
1	Архангай	Засаг даргын нөөц хөрөнгийг журмын дагуу зарцуулсан эсэх
2	Баянхонгор	Нийгмийн халамжийн хөнгөлөлт үйлчилгээний чанар хүртээмж, үйлчилгээний төрөл, зардлын үр ашиг
3	Баянхонгор	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн зарцуулалт ангийн орлого, түгээмэл тархацтай ашигт малтмалын орлого /2016-2019 он/
4	Булган	Байгаль хамгаалах сангийн хөрөнгийн 2019 оны үйл ажиллагааны үр дүн
5	Булган	Ойн тухай хуулийн хэрэгжилтийн үр дүн
6	Говь-Алтай	Говийн их дархан цаазат газрын "А" хэсгийн хамгаалалтын захиргааны үйл ажиллагаа, хөрөнгийн зарцуулалт
7	Говь-Алтай	Говийн их дархан цаазат газрын "Б" хэсгийн хамгаалалтын захиргааны үйл ажиллагаа, хөрөнгийн зарцуулалт
8	Говьсүмбэр	Аймгийн ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж, шийдвэрийн үндэслэл, түүний хэрэгжилт
9	Говьсүмбэр	Худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийн хэрэгжилтэд нийцлийн аудит хийх
10	Дархан-Уул	Дархан сумын ЗДТГ-ын 2018, 2019 оны үйл ажиллагаа, үр дүн
11	Дорноговь	Орон нутагт тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа дүрэм, журмын хэрэгжилт, үр дүн
12	Дорноговь	Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилт
13	Дорноговь	МСҮТ болон ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр болон цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын зарцуулалт, үр дүн
14	Дорнод	Төрд учруулсан хохирлыг нөхөн төрүүлэх, хяналт тавих хууль, тогтоомжийн хэрэгжилт
15	Дорнод	Гадаадаас ажиллах хүч авч ажиллуулахтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилт
16	Дундговь	Орон нутгийн өмчийн бодлого, хууль журмын хэрэгжилт
17	Завхан	Сумдын сум хөгжүүлэх сангийн 2019 оны зарцуулалт, үр дүн
18	Өвөрхангай	"Арвайхээр Цэцэрлэгжилт" ОНӨААТҮГ-ын 2018, 2019 оны үйл ажиллагааны үр дүн
19	Сүхбаатар	Хүнс хөдөө аж ахуйн газрын төсвийн зарцуулалт, хууль тогтоомжийн хэрэгжилт
20	Сэлэнгэ	Аж ахуйн нэгж байгууллагуудын зүгээс нутгийн захиргааны байгууллагуудтай байгуулсан нийгмийн хариуцлагын гэрээний хэрэгжилт, үр дүн
21	Сэлэнгэ	Аймгийн ИТХ-ын "2019 онд ойгоос бэлтгэх модны дээд хэмжээг батлах тухай", "2019 онд ахуйн зориулалтаар агнах, барих амьтны тоо хэмжээг тогтоох тухай" тогтоолуудын хэрэгжилт
22	Төв	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн хэрэгжилт /2016-2019/
23	Увс	Малчин сумын төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагааны үр дүн /2017-2019/
24	Увс	Түргэн сумын төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагааны үр дүн /2017-2019/
25	Ховд	Бичил уул уурхай ашигт малтмал олборлох журмын хэрэгжилт

ЦААСНЫ ХЭРЭГЛЭЭГ БАГАСГАЯ!



787км-тэй
дүйцэхүйц урт
ажлын баримт материал



1.2 ТВ
ажлын файл



ТӨРИЙН АУДИТ
СОНИРХОЛТОЙ
СТАТИСТИК **2020**

Аудитын тайлангийн
цахим хувилбарыг QR
кодоор үзнэ үү





Үндэсний аудитын газар
/Засгийн газрын IV байр/



www.audit.mn



info@audit.gov.mn



(+976) 62-264230



(+976) 62-264230